



# Зөвлөмжийн Цуврал

## ЗЦ102-1

Нэмэлт, өөрчлөлт 1 (0)

### Хүнгүй Агаарын Хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлт

2022 оны 12 сарын 9

#### Ерөнхий зүйл

ИНЕГ-ын АС нь холбогдох ИНД-ийг дагаж мөрдүүлэх зорилгоор Даргын зөвшөөрсөн стандарт, практик, журмуудын талаарх мэдээллийг агуулдаг.

Даргад танилцуулах нийцлийн бусад аргуудыг ч анхаарч үзэх бөгөөд шинээр стандарт, практик, журам хүлээн зөвшөөрөгдөхөд холбогдох АС-д нь нэмж оруулна.

Түүнчлэн, энэхүү АС нь дүрмийн шаардлагыг хангах зааварчилгаа материалыг агуулна. Зааварчилгаа материал нь хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрт тооцогдохгүй.

#### Зорилго

Энэхүү АС нь ИНД-102-ын дагуу хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшихэд тавигдах шаардлагыг биелүүлэх зааварчилгаа, зөвлөгөөгөөр хангахад оршино.

#### Холбогдох Дүрмүүд

Энэхүү АС нь ИНД-102-той хамааралтай ч ИНД-101-ийн дагуу үйл ажиллагаа эрхлэгчид тавигдах шаардлагад мөн хамаарна.

#### Өөрчлөлтийн мэдэгдэл

Гишүүн улсуудын ИНД-ийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг боловсруулсан.

ЗЦ102-1-ийг монгол болон англи хэл дээр боловсруулсан бөгөөд хэрэв эдгээрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хэл дээрх хувилбарыг баримтална.

ЗЦ102-1-ийг NZ АС102-1-ийн 2015 оны 7 сарын 27-ны өөрчлөлт 0-д үндэслэн боловсруулсан болно.

## Гарчиг

<b>Тайлбар</b> .....	<b>3</b>
<b>Оршил</b> .....	<b>4</b>
<b>Энэ АС (АС) ямар агаарын хөлөгт хамаарах вэ?</b> .....	<b>5</b>
Загварын агаарын хөлгийн хувьд? .....	5
<b>Дүрмүүд 102.1 Зорилго, 102.3 Хамрах хүрээ болон 102.7 Гэрчилгээний шаардлага 7</b>	
Надад гэрчилгээ хэрэгтэй юу? .....	7
Би ИНД-101, эсхүл ИНД-102-ын алиныг баримтлан ажиллахаа хэрхэн мэдэх вэ? .....	7
Ерөнхий зааварчилгаа материал .....	8
102.9 Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэхээр гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах .....	16
102.11 Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн Ерөнхий заавар .....	16
102.11(b) Ерөнхий зүйл: .....	17
102.11(b)(1) Үндсэн үүрэг хариуцлага хүлээх этгээд: .....	17
102.11(b)(2) Хяналт тавих этгээд: .....	17
102.11(b)(3) Үйл ажиллагааны бүс: .....	18
102.11(b)(4) Аюулын бүртгэл: .....	18
102.11(b)(5) Мэдээлэл өгөх: .....	18
102.11(b)(6) Үнэмлэхжүүлэлт болон мэргэшил: .....	19
Агаарын хөлгийн дарга болон удирдах хүмүүс .....	19
Ажиглагч / багийн бусад гишүүн .....	20
Нислэгийн цагийн бүртгэл болон үйл ажиллагааны туршлага .....	21
102.11(b)(7) Ашиглах агаарын хөлгийн дэлгэрэнгүй: .....	21
102.11(b)(8) Удирдлагын систем: .....	22
102.11(b)(9) Агаарын хөлгийн техник үйлчилгээ: .....	22
102.11(b)(10) Үйл ажиллагааны журам: .....	23
102.11(b)(11) Ачаа тээвэрлэх болон эд зүйлийг агаараас хаях: .....	24
102.11(b)(12) Хүнгүй агаарын хөлгийг зохион бүтээх болон загвар: .....	24
102.11(b)(13) Ерөнхий зааврын нэмэлт, өөрчлөлт болон түгээлт .....	26
102.11(b)(14) Зөвшөөрөл .....	26
102.11(c) Лавлагаагаар хэрэглэх .....	27
102.11(d) Даргын саналаар болох .....	27
102.13 Гэрчилгээ олгох .....	27
Нисэхийн аюулгүй байдал .....	28
102.13(b)(1) Шаардлагууд .....	28
102.13(b)(2) Нөхцөлүүд .....	29
102.13(b)(3) Тэмдэглэгээ .....	29
102.15 Үйл ажиллагааны тодорхойлолт .....	29
102.17 Гэрчилгээ эзэмшигчийн эрх .....	30
102.19 Гэрчилгээний хугацаа .....	30
102.21 Хүнгүй агаарын хөлгийн үйл ажиллагааны нөхцөл .....	30
102.23 Ерөнхий зааварт өөрчлөлт оруулах .....	30
102.25 Гэрчилгээ сунгах .....	31

## Тайлбар

Дараах нэр томъёог энэ баримт бичигт ашигласан.

АС	зөвлөмжийн цуврал
AGL	газрын түвшнээс дээш
AIP	нисэхийн мэдээллийн эмхэтгэл
НХУ	нислэгийн хөдөлгөөний удирдлага
ШХУУАГ	шууд харж удирдах ажиллагаанаас гадна
НХЗ	нислэгийн хөдөлгөөний зохицуулалт
ИХЦ	ил хараанаас цаашхи
ИНД	иргэний нисэхийн дүрэм
ИНЕГ	иргэний нисэхийн ерөнхий газар
НШХУА	нэмэгдүүлсэн шууд харж удирдах ажиллагаа
ДДХУ	дүрсийг дэлгэцээр харж удирдах
ОУИНБ	олон улсын иргэний нисэхийн байгууллага
IAW	-ийн дагуу
LAME	агаарын хөлгийн техник үйлчилгээний үнэмлэхтэй инженер
ХХЖ	хүчинтэй хуудасны жагсаалт
СХАХ	спортын хөнгөн агаарын хөлөг
MFM	Model Flying Mongolia
NM	далайн миль
AU	алсын удирдлага
RPA	зайнаас удирддаг агаарын хөлөг
RPAS	зайнаас удирддаг агаарын хөлгийн систем
SMS	аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо
ҮАСЖ	үйл ажиллагааны стандарт журам
ББГ	багийн бусад гишүүн
ХАХ	хүнгүй агаарын хөлөг
UAS	хүнгүй агаарын хөлгийн систем(-үүд)
UAV	хүнгүй нисэх төхөөрөмж
ХАХҮАЭГ	хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ
ШХУА	шууд харж удирдах ажиллагаа
VMC	ил харааны нислэгийн цаг уурын нөхцөл

## Оршил

Сүүлийн жилүүдэд зайнаас удирддаг агаарын хөлгийн системийг (RPAS) иргэд ашиглах нь ихээхэн нэмэгдэж байна. Судалгаа шинжилгээ, хөгжүүлэлт зэрэгт RPAS ашиглах нь хурдацтай хөгжиж буй салбар болж байна. Өмнө, гүйцэтгэх боломжгүй байсан, өндөр өртөгтэй, эсхүл хувь этгээдийн хувьд эрсдэлтэй байсан үйл ажиллагааг өдгөө эдгээр төрлийн агаарын хөлгөөр гүйцэтгэх удирдлага, арга ажиллагааны систем бүрэлдэж байна. Иймд RPAS нь нислэгийн хяналттай болон хяналтгүй орон зайд орж ирэх, оршин ашиглагдах явдал нэмэгдэж эхэлсэн.

RPAS-ийн хэрэглээний өсөлт нь одоогийн байдлаар агаарын хөлгийн загвар хөлгүүдтэй ижил төстэй овор хэмжээтэй (гэвч нислэг гүйцэтгэлийн чадварын хувьд адил байх шаардлагагүй) жижиг агаарын хөлгүүд дээр төвлөрч байна. Гэсэн хэдий ч илүү том овор хэмжээтэй, уламжлалт агаарын хөлгийн хэрэглээ мөн өссөөр байна.

Энэхүү АС-ын зорилго нь үйл ажиллагаа эрхлэгчээс ИНД-102-ын дагуу гэрчилгээ авахад юуг тэд хийж болох, болохгүйг ойлгож мэдэхэд туслах зорилгоор зааварчилгаа, тайлбар материалаар хангах явдал.

АС-ыг ИНД-102-ын дагуу гэрчилгээжих үйл ажиллагааны хамрах хүрээний талаарх илүү их мэдээлэл, ойлголт авахад нэмэлт болох динамик баримт бичиг гэж үзэх ёстой. RPAS-ийн салбарт аюулгүй ажиллагаа болон технологийн дэвшлийн шинэ мэдээллийн үр дүнд Өөрчлөлтийг гаргана. АС-д үйл ажиллагаа эрхлэгч нь RPAS-ийн тодорхой төрлийн хүсэлтийн тухайд юу хийх, хийхгүй талаар зааварласан буюу бүхэлд нь хамарсан мэдээллээр хангахгүй; харин үйл ажиллагаа эрхлэгч ИНД-102-ын дагуу гэрчилгээжихээр ИНЕГ-т хүсэлт гаргахаар бэлтгэхэд зааварчлах зорилготой.

Цаашид удирдамж, дагаж мөрдөх зөвлөгөө шаардагдах үед бид АС-ыг байнга шинэчилнэ. ИНЕГ нь АС-ээр ач холбогдолтой зөвлөгөөг урьдчилан өгөх зорилгоор хандлага болон тулгарч байгаа эрэлт хэрэгцээнд ажиглалт хийнэ.

ИНД-101 болон ИНД-102 нь хоорондоо харилцан хамааралтай үйлчилнэ. ИНД-102-ыг одоогоор хүнгүй агаарын хөлгийн 'бие даасан' дүрэм болгон боловсруулсан боловч ИНД-102-ын гэрчилгээнд өөрөөр заагаагүй бол хүсэлт гаргагч нь ИНД-101-ийн чухал шаардлагыг биелүүлэх шаардлагатай болохыг онцлох нь чухал. ИНД-102 нь төлөвлөсөн ажиллагаа бүрд тохирсон аюулгүй байдал болон үйл ажиллагааны шаардлагыг тохируулах сонголт өгөх хүнгүй агаарын хөлгийн уян хатан, ерөнхий тогтолцоогоор Даргыг хангана. Хүнгүй агаарын хөлгийн технологи хурдан өсч байгаа учраас энэхүү хандлага нь үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг тооцохын зэрэгцээ эдгээр агаарын хөлөгт шаардлагатай хууль зүйн дэглэмийг баталгаажуулна.

25кг-аас бага жинтэй, зөвхөн ИНД-101-ийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэдэг хүнгүй агаарын хөлөг нь энэхүү АС-ын гол хэсэг биш. Эдгээр агаарын хөлгийн холбогдох шаардлагыг ИНД-101 болон АС 101-1-ээс үзэх.

## Энэ АС (АС) ямар агаарын хөлөгт хамаарах вэ?

Эдгээр агаарын хөлгүүд гэсэн нэр томъёог тайлбарлахад хэрэглэх хүнгүй нисэх төхөөрөмж (UAV), хүнгүй агаарын хөлгийн систем (ХАХС), дрон болон агаарын хөлгийн загвар зэргийг багтаасан маш олон нэр томъёо бий.

ИНД-101 болон 102-т тэдгээрийн өөр өөр хэсгийг тодорхойлсон олон тооны ялгаатай нэр томъёог хэрэглэнэ. Хялбарчлахын тулд тэдгээрийг дор жагсаан харуулсан.

ИНД-102-ийн дагуу гүйцэтгэх үйл ажиллагаанд түлхүүр үг нь “хүнгүй агаарын хөлөг” юм.

Хүнгүй агаарын хөлөг гэдэгт хүнгүй агаарын бөмбөлөг, цаасан шувуу, утсан удирдлагатай болон чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар, зайнаас удирддаг агаарын хөлөг багтана”.

Энэ дүрэм нь мөн хүнгүй агаарын хөлгийн систем буюу-

“бүхээгтээ нисгэгчгүй үйл ажиллагаа гүйцэтгэдэг агаарын хөлөг болон түүний холбогдох элемент”-д хамаарна.

ИНД-102 нь ИНД-101-ийн дагуу үйл ажиллагаа явуулдаггүй бусад бүх хүнгүй агаарын хөлөгт хамаарна. Үүнд бүх төрлийн бүрэн бие даан үйл ажиллагаа явуулдаг агаарын хөлөг (үүнийг автоматаар ажиллахаар програмчлагдах боломжтой болон үйл ажиллагаа нь автоматжлагдах боломжтой ч оператор удирдлагыг өөр дээрээ авч болохуйц RPAS-тай андуурч болохгүй) хамаарна.

ИНД-101-д “зайнаас удирддаг агаарын хөлөг” гэх нэр томъёог ашиглана. Энэ нь хүнгүй агаарын хөлгийн дэд ангилал юм. “зайнаас удирддаг агаарын хөлөг” гэж:

‘алсын удирдлагаар нисгэдэг хүнгүй агаарын хөлгийг, үүнд:

- (1) радио удирдлагатай агаарын хөлгийн загвар багтана, гэхдээ
- (2) утсан удирдлагатай, эсхүл чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар багтахгүй’.

Зайнаас удирддаг агаарын хөлөг гэдэгт түүний алсын удирдлагын станц, эсхүл станцууд, шаардлагатай удирдлагын болон хяналтын шугам, мөн тухайн системийг ажиллуулахад шаардлагатай бусад хэрэгсэл багтана.

Энэ АС-д холбогдох хэрэгжүүлэлтийн зөвлөмжийг оруулах зорилгоор, бид дараах тодорхойлолтыг хэрэглэнэ.

Жижиг хүнгүй агаарын хөлөг гэж 25 кг-аас доош жинтэй агаарын хөлгийг;

Дунд хүнгүй агаарын хөлөг гэж 25-аас 150 кг хүртэлх жинтэй агаарын хөлгийг;

Том хүнгүй агаарын хөлөг гэж 150 кг-аас дээш жинтэй агаарын хөлгийг хэлнэ.

## Загварын агаарын хөлгийн хувьд?

Агаарын хөлгийн загварыг уламжлалт ёсоор сонирхогчийн зүгээс зөвхөн сонирхогчийн зорилгоор нисгэдэг хүнгүй жижиг агаарын хөлөг гэж тооцдог. Хэдийгээр ИНД-101-д чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар болон утсан удирдлагатай агаарын хөлгийн загвар зэргийг багтаасан “агаарын хөлгийн загвар” нэртэй дэд

ангилал байгаа боловч “агаарын хөлгийн загвар” гэх ерөнхий нэр томъёо байхгүй байна.

Агаарын хөлгийн загварыг ИНД-101-ийн хүрээнд “зайнаас удирддаг агаарын хөлөг”, ИНД-102-ийн хүрээнд хүнгүй агаарын хөлөгт хамааруулах болсон. Эдгээр Дүрэмд зайнаас удирддаг агаарын хөлгийг арилжааны, эсхүл сонирхогчийн зорилгоор ашиглах гэж ялгадаггүй.

Энэ нь арилжааны, эсхүл сонирхогчийн зорилгоор ашиглах агаарын хөлгүүдийн хоорондох агаарын нислэгтэй холбоотой эрсдэл маш бага ялгаатай гэж үздэг ИНЕГ-ын хандлагад тусгалаа олсон байна. Жнь: жижиг хүнгүй агаарын хөлгөөр агаараас зураг авах, эсхүл видео бичлэг хийх нь тухайн зураг, эсхүл видео бичлэгийг зарж борлуулах, эсхүл хувийн хэрэгцээнд ашиглах гэж байгаагаас үл хамааран түүнээс иргэн, өмч хөрөнгөнд учруулах эрсдэл нь ижил байна. Хамгийн чухал нь иргэн, өмч хөрөнгөнд учруулж болох эрсдэлийг аль ч тохиолдолд хянаж байх явдал юм.


Иймд “агаарын хөлгийн загвар” нь зайнаас удирддаг агаарын хөлгийн тодорхойлолттой нийцэх ба үүнийг ИНД-101, хэрэв ИНД-101-д заасан хязгаарлалтаас давсан бол ИНД-102-ын дагуу зохицуулна.

## Дүрмүүд 102.1 Зорилго, 102.3 Хамрах хүрээ болон 102.7 Гэрчилгээний шаардлага

### Надад гэрчилгээ хэрэгтэй юу?

Хэрэв та ИНД-101-ийн хязгаарлалтын хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэж чадахгүй хүнгүй агаарын хөлгийг ажиллуулах гэж байгаа бол, танд ИНД-102-ын дагуу авсан хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ шаардлагатай. Зураг [1] нь үйл ажиллагаа эрхлэгчийг үзэж, шийдэх замыг гаргасан байна.

### Зураг [1]



### Би ИНД-101, эсхүл ИНД-102-ын алиныг баримтлан ажиллахаа хэрхэн мэдэх вэ?

ИНД-101-ийн хүрээнд мөрдөж ажиллахыг шаардсан 12 гол шаардлага бий.

Та дараах шаардлагыг биелүүлэх ёстой:

- (1) 25кг, эсхүл түүнээс дээш жинтэй агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байх, мөн үйл ажиллагаа гүйцэтгэхдээ аюулгүй байдлыг байнга хангах;
- (2) цаг үргэлж хүн, өмч хөрөнгө болон агаарын хөлөгт учирч болох аюул болон эрсдэлийг арилгах, багасгах бүх арга хэмжээг авах (тухайлбал аюултай болон эрсдэлтэй аливаа үйлдэл, эс үйлдэл хийхгүй байх);
- (3) зөвхөн өдрийн цагаар нисгэх;
- (4) бүх хүнгүй агаарын хөлөгт зам тавьж өгөх;
- (5) агаарын хөлгийг өөрийн нүдээр харж хянах боломжтой байдлаар нисгэх (гэхдээ дуран, дэлгэц, эсхүл ухаалаг утас зэргийг ашиглахгүй), бусад агаарын хөлгөөс хол зай барих (эсхүл үүнийг тусгай ажиглагчаар хянуулах);

- (6) агаарын хөлгийг AGL 120м-ээс (400ft) өндөрт нисгэхгүй байх (тодорхой нөхцөлийг хангаснаас бусад тохиолдолд);
- (7) үйл ажиллагаа гүйцэтгэхээр зорьж байгаа агаарын зайд хүчинтэй үйлчилж байгаа хязгаарлалтын талаар мэдлэгтэй байх;
- (8) аливаа аэродромоос гадагш 4км дотор нисгэхгүй байх (тодорхой нөхцөлийг хангаснаас бусад тохиолдолд);
- (9) хяналттай агаарын зайд нислэг үйлдэх бол НХУ-аас зөвшөөрөл авах;
- (10) бүсийн хяналтын эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй тусгай хэрэгцээний агаарын зайд нислэг үйлдэхгүй байх (жнь: цэргийн үйл ажиллагааны бүс, нам өндрийн нислэгийн бүс, эсхүл хязгаарлалттай бүс);
- (11) аливаа этгээдийн дээгүүр нисгэхдээ зөвшөөрөл авах;
- (12) аливаа газрын дээгүүр нислэг үйлдэхдээ өмчийн эзэн, эсхүл тухайн газрыг хариуцсан этгээдээс зөвшөөрөл авах.

Энэ жагсаалт нь ИНД-101-д холбогдох бүх заалтыг орлохгүй. Та ИНД-101, эсхүл 102-ын дагуу үйл ажиллагаа гүйцэтгэхээс өмнө тухайн үйл ажиллагаандаа нарийн дүгнэлт хийхээс гадна, холбогдох ИНД-ийг бүрэн ойлгож байгаа эсэхээ бататгасан байх ёстой.

Дүрмийн зарим заалтад чөлөөлөлт үйлчилж болох хэдий ч ерөнхийдөө хэрэв таны үйл ажиллагаа эдгээр шаардлагын аль нэгийг хангахгүй байгаа бол энэ нь таны үйл ажиллагаа ИНД-102-ын дагуу гэрчилгээжих шаардлагатай болохыг харуулж байгаа юм.

## **Ерөнхий зааварчилгаа материал**

### ***Төлөвлөсөн үйл ажиллагааныхаа тухай бодох***

Та, ИНД-102-ын дагуу хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлтийг ИНЕГ-т гаргахын өмнө төлөвлөсөн үйл ажиллагааныхаа хамрах хүрээг сайн бодох хэрэгтэй.

Дараах зарим хэрэгтэй асуулт нь таны үйл ажиллагаанаас гарах эрсдэлийн түвшинг тогтоож, зохих зохицуулалтын хариултыг өгнө. Доорх асуултын жагсаалт нь хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн алсдаа авч үзэх зарим зүйл болон ИНЕГ-ын RPAS-ийн хүчин чадал болон өнөөдрийн Монгол Улсын RPAS-ийн орчны талаарх ойлголтод үндэслэсэн зааварчилгааг өгнө. Энэ АС нь өөр өөр хэрэглээ, эсхүл ашиглалтад тавигдах тусгайлсан шаардлагыг заагаагүй; хүсэлт бүрийг тус тусад нь авч үзнэ. Та тогтоосон аюул болон үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг хэрхэн шийдвэрлэхээр зорьж байгаагаа харуулна.

Дараах асуулт нь таны биелүүлж чадахгүй ИНД-101-ийн зарим шаардлагыг шийдвэрлэхэд туслах ба иймд хүсэлтээ бэлдэхэд онцгой анхаарал хандуулах хэсэг.

Та 25кг-аас дээш жинтэй агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхийг хүсч байна уу?

Хэрэв та 25кг+-ын бохир жинтэй агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхийг хүсвэл, автоматаар ИНД-102-д хамрагдана. Танд, үүнээс дээш жинтэй агаарын хөлгөөр зөвхөн ИНД-102-ын гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэхийг зөвшөөрнө.



25кг бохир жинд агаарын хөлгийн зөөвөрлөж байгаа аливаа ачаа багтана.

Та 15 кг-аас дээш жинтэй агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхийг хүсч байна уу?

Хэрэв та 15кг-аас дээш, гэхдээ 25кг-аас дээшгүй жинтэй агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхийг хүсвэл та ИНД-102-т хамрагдана.

15-аас 25кг-ын хооронд жинтэй агаарын хөлгөөр хэрэв зөвшөөрөгдсөн байгууллагын эрхийн хүрээнд зохион бүтээсэн, үйл ажиллагаа гүйцэтгэдэг бол зөвхөн ИНД-101-ийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж болно.

Зөвшөөрөгдсөн байгууллага болох талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ИНЕГ-аас авна уу.

***Та шөнийн цагаар үйл ажиллагаа гүйцэтгэхээр зорьж байна уу?***

Хэрэв та шөнийн цагаар нисгэхийг хүсвэл, хүсэлтдээ эдгээрийг хэрхэн шийдвэрлэх тайлбарыг тусгасан байх ёстой:

- таны агаарын хөлгийн гэрэлтүүлэг/төхөөрөмж нь бусад зайнаас удирддаг агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч, эсхүл хүнтэй агаарын хөлөгт харагдахаар байх;
- та агаарын хөлгөө хэрхэн харж байх;
- төлөвлөсөн нислэгийн бүс;
- газар дээрх хүн, эсхүл өмч хөрөнгөнд учрах эрсдэл;
- яаралтай тусламжийн үйлчилгээнд нислэгийн талаар мэдэгдэх.

‘Өдөр’ гэдэг нэр томъёо нь AIP-д заасантай ижил – Үүнийг Өдрийн гэрэл гэсэн Хүснэгтээс <https://www.ais.mn>-аас үнэгүй харах боломжтой. Эдгээр хүснэгт нь Монгол Улсын эргэн тойрон дахь өөр өөр байршлууд болон албан ёсоор өдрөөс шөнөд, шөнөөс өдөрт шилжих цаг хугацааг заасан.

***Та олон хүн цугласан, эсхүл шигүү суурьшлын бүс дээгүүр нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхийг хүсч байна уу?***

Олон хүмүүс цугласан, эсхүл хүмүүс байгаа шигүү суурьшлын бүс дээгүүр үйл ажиллагаа гүйцэтгэх нь үнэхээр аюултай.

Олон, эсхүл шигүү хүмүүсээс бүрдсэн спорт, эсхүл бусад арга хэмжээнд байгаа хүмүүсийн дээгүүр, эсхүл ойролцоо үйлдэх нислэг нь нэмэлт эрсдэлийг авчирна.

Хүсэлт гаргагч нь хүсэлт гаргахдаа дараах асуудлыг авч үзнэ:

- аюул болон эрсдэлийг тогтоох, үүнд цугларсан олон хүн, эсхүл оролцож буй хүмүүст улам бүр нэмэгдэх аюулыг тогтоох;
- агаарын хөлгийн конфигураци (далавчит эсрэгээр олон сэнст, эсхүл дирижабль);
- машины найдвартай байдал;
- удирдлагын системийн найдвартай байдал;
- системд эвдрэл гарсан тохиолдолд засах арга хэмжээ авах;
- системийн нөөц (жнь:хүлээн зөвшөөрөх автомат сэргээх шүхэр);

- хэрэв боломжтой бол, үйл ажиллагаанд оролцож байгаа хүмүүст зөвшөөрөл авах, эсхүл мэдээлэл өгөх зорилгоор үйл ажиллагаа эрхлэгчийн санал болгож байгаа алхам.

Хүмүүс байгаа, эсхүл хүмүүсийн ойролцоох барилга, байгууламжтай ойрхон нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх нь мөн аюултай байж болно. Хэрэв та барилга, байгууламжтай ойрхон агаарын хөлөг ашиглахыг санал болгож байгаа бол дараах нэмэлт асуудлыг шийдэх хэрэгтэй:

- байгууламж, эсхүл объектод учрах нөлөөг шийдвэрлэх журам;
- агаарын хөлөг унасан тохиолдолд аюулгүй байдлын периметрийг хангахын тулд олон хүн цуглах/орохыг хянах.

### ***Та шууд харж удирдах ажиллагаанаас гадна нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхийг хүсч байна уу (BVLOS)?***

Бид ойрын ирээдүйд стандарт үйл ажиллагааны орчин нь харааны хэрэгсэлгүй шууд харж удирдах системд үйл ажиллагаа гүйцэтгэх орчин нь байна гэдэгт итгэлтэй байна. урьдчилан мэдэгдэж болох ирээдүйн стандарт үйл ажиллагааны орчин нь тусламжгүй 'unaided' харагдах харааны шугамын (VLOS) дотор байна гэж бодож байна. 'Тусламжгүй' гэдэг нь үйл ажиллагаа эрхлэгч агаарын хөлгийг дуран, эсхүл телескоп г.м хэрэгсэл ашиглахгүй харж чадах юм.

ИНД-102 нь шууд харж удирдах ажиллагааг хориглодоггүй ч, энэ төрлийн ажиллагаа нь үйл ажиллагаа эрхлэгчид хэд хэдэн хүндрэлийг учруулдаг. Эдгээр үйл ажиллагаатай холбоотой эрсдэл гэдэг нь хэрэв та шууд харж удирдах үйл ажиллагаа гүйцэтгэхийг зорьж байгаа бол, та хүсэлтдээ аюулгүй байдлын баталгаатай байдлыг харуулах юм. Аюулгүй байдлын нөхцөлийн зарим үзүүлэлтэд дараах орж болно:

- ашиглах агаарын зайн ангиллыг тодорхойлох болон холбогдох шаардлага, тэдгээрийг хэрхэн хангах;
- бусад хөдөлгөөнөөс зайчлал хангах чадвар, тухайлбал тусгаарлан ангилсан агаарын зай, эсхүл технологийн шийдэл (жнь: хайх, илрүүлэх болон зайлсхийх систем);
- хүн, өмч хөрөнгө болон нутаг дэвсгэрт учруулах эрсдэлийг багасгах.

Үйл ажиллагааг зөвшөөрөхөөс өмнө тухайн агаарын зайг тогтоосон байх зорилгоор тусгаарлан ангилсан агаарын зайд гүйцэтгэх шууд удирдах үйл ажиллагаа нь явуулах BVLOS ажиллагааг зөвшөөрөхийн өмнө тухайн агаарын зайг тогтоох зөвшөөрлийг авсан байх ёстой.

Хүсэлт гаргагч нь ИНД-71-д заасан эрхийн дагуу тусгай хэрэгцээний агаарын зайг (цэргийн үйл ажиллагааны бүс, хязгаарлагдмал бүс, эсхүл аюултай бүс) байнга, болон/эсхүл олон байрлалд тогтоох нь тогтсон нисэхийн системийг алдагдуулж болзошгүйг мэдэж байх хэрэгтэй. Зарим тохиолдолд, нисэхийн ажиллагааны ачаалал багатай бүсэд судалгаа болон тест хийх г.м хязгаарлалттай тоо болон тодорхой зорилгоор ашиглахаас бусад тохиолдолд нисэхийн тусгай хэрэгцээний агаарын зайг ашиглах нь хэрэгжүүлж болохуйц шийдэл биш болно.

Дүрсийг дэлгэцээр харж удирдах систем ашиглан, эсхүл нисгэгчээс анхаарал шаардах алсын төхөөрөмжөөс нислэг үйлдэж байгаа хүнгүй агаарын хөлөг нь

агаарын хөлөгтэй бүх хугацаанд холбоотой байх туслах хэрэгсэлгүй шууд харж удирдах ажиллагааг хадгалах ажиглагч шаарддаг. Энэхүү ажиглагч нь бусад зүйлсийн хажуугаар нисгэгчид үйл ажиллагааны бүсэд орж байгаа аливаа бусад хөдөлгөөнийг мэдээлнэ.

Ажиглагчгүй дүрсийг харж удирдах ажиллагааг шууд харж удирдах ажиллагаа гэж тооцох бөгөөд энэ нь үйл ажиллагаа эрхлэгчээс дээр дурдсан аюулгүй байдлын талаарх асуудлыг шийдвэрлэхийг шаардана.

***Би шууд харж удирдах ажиллагаагаа нэмэгдүүлэхийн тулд ажиглагч ашиглаж болох уу?***

Нэмэгдүүлсэн шууд харж удирдах ажиллагаа гэдэг нь нисгэгч/үйл ажиллагаа эрхлэгчтэй шууд холбоотой байгаа, бүсийн хил дээрх ажиглагчийг ашиглан, агаарын зайн нэмэгдсэн бүсийг ажиглахыг хэлнэ. Ажиглагч нь үйл ажиллагааны бүсэд өөр бусад хөдөлгөөн оруулахгүй байлгаж, зайчлалаар хангана.

Энэ үйл явцыг сайн ашиглаж байгаагийн тод жишээ бол цахилгааны шугамыг судлах юм. Үүнийг мөн хүнгүй агаарын хөлгийг ашиглаж болох хөдөө аж ахуйн зарим нарийн ажлыг шийдвэрлэх боломжтой шийдэл гэж үздэг.

Хэрэв та тухайн үйл ажиллагааг холбогдох багийн бусад гишүүнтэй гүйцэтгэж, хүнгүй агаарын хөлгийг бусад агаарын хөлгөөс зайчлахаа бататгаж чадахын бол нэмэгдүүлсэн шууд харж удирдах системийг зөвшөөрч болно. Хэрэв та нэмэгдүүлсэн шууд харж удирдах системийн үйл ажиллагааг гүйцэтгэхийг хүсэхийн бол та бүсэд байгаа нисэхийн бусад үйл ажиллагаатай (жнь: хөдөө аж ахуйн үйл ажиллагааны хувьд бусад хүнгүй хөдөө аж ахуйн нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч, эсхүл орон нутгийн нисдэг тэрэгний үйл ажиллагаа эрхлэгчид) холбоотой байж, тэднийг хэзээ, хаана тодорхой бүсэд нисэхийг мэдэж, тэдэнд болох гэж байгаа хүнгүй агаарын хөлгийн нислэгийг мэдэгддэг журамтай байх ёстой.

***Та 400 ft-ээс дээш нисэхийг хүсч байна уу?***

ИНД-101-ийн дагуу, үүлний суурийн өндөр зайнаас удирддаг агаарын хөлгийн нислэгийн дээд хязгаар нь 400ft байдаг (зарим онцгой тохиолдол бий).

Энэхүү дээд хязгаарын зорилго нь уламжлалт агаарын хөлөг болон ИНД-101-ийн дагуу нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн хооронд завсар хэсэг бий болгох юм.

Тэдэнд бодит шалтгаан байхаас бусад тохиолдолд уламжлалт агаарын хөлгөөр ерөнхийдөө 500ft-ээс доош өндөрт нислэг үйлдэхийг зөвшөөрөхгүй. Уламжлалт агаарын хөлөг хөдөө аж ахуйн үйл ажиллагааны зорилгоор 500ft-ээс доош өндөрт нислэг үйлдэж болно. Мөн агаарын хөлөг нь буулт болон хөөрөлт үйлдэхдээ 500ft-ээс доош өндөрт үйл ажиллагаа гүйцэтгэж болно. Иймээс алсын удирдлагатай агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь бүх хүнтэй агаарын хөлөгт зам тавьж өгөх үүрэгтэй. Зам тавьж өгөх дүрэм нь ИНД-102-ын гэрчилгээнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд ИНД-101 болон ИНД-102-ын үйл ажиллагаанд хамаарна.

Хэрэв та 400ft-ээс дээш нисэхийг хүсч байгаа бол эхлээд нисэх гэж байгаа агаарын зайн ангиллыг мэдэх/тогтоох хэрэгтэй. Таны нисэх гэж байгаа агаарын зайнаас шалтгаалан өөр өөр дүрмүүд үйлчилнэ. Хэрэв танд зөвшөөрөл, эсхүл транспондер зэрэг тусгай төхөөрөмж шаардлагатай, эсхүл тухайн үйл ажиллагаанд тавигдах

аливаа бусад нөхцөлийг дагаж мөрдөх шаардлагатай бол үүнийг ойлгохын тулд ИНЕГ-аас зөвлөгөө авах хэрэгтэй.

***Та аэродромоос 4км дотор нисэхийг хүсч байна уу?***

Хэрэв халхлагдсан үйл ажиллагаа бол та аэродромоос 4км дотор агаарын хөлөг ашиглаж болно. Халхлагдсан үйл ажиллагааг ИНД-101-д тодорхойлсон. Жнь: стадионы дээврийн өндрөөс доош хийх нислэг, эсхүл ой модтой газар модны өндрөөс доош хийх нислэг байж болно.

Хэрэв та хяналтгүй аэродромоос 4км дотор халхлагдаагүй үйл ажиллагаа гүйцэтгэхийг хүсч байгаа бол үүнээс гарах эрсдэлийн талаарх ойлголт мөн эдгээр эрсдэлийг удирдан зохицуулж чадахаа харуулах нь чухал. Хэрэв та ИНД-101-ийн дагуу аэродром эзэмшигчтэй хэлэлцээрт хүрч чадахгүй бол, энэ шаардлагыг заагаагүй ИНД-102-ын гэрчилгээг авч болно.

Гэхдээ ингэхийн тулд, та дараах зүйлийг сайтар бодсон гэдгээ харуулах нь чухал:

- юу хийх гэж байгаагаа нислэгийн талбайн үйл ажиллагаа эрхлэгчид хэрхэн мэдэгдэх;
- зохих давтамжийг хэрхэн хянах;
- яригдаж байгаа хүнтэй аэродромын аюулгүй байдлыг хангахтай холбоотой өөр ямар нэгэн зүйл.

Мөн та аэродромын ойролцоо ажиллах болон НХУ-тай холбоо тогтоох шаардлагатай техникийн төхөөрөмжийг ашиглах заавал шаардлагатай мэдлэг болон чадвартай гэдгээ дараах байдлаар харуулах нь чухал:

- ИНД-61-ийн дагуу олгосон нисгэгчийн үнэмлэх;
- ИНД-149-ийн дагуу олгосон нисгэгчийн гэрчилгээ;
- Зөвшөөрөгдсөн байгууллагаас олгосон нисгэгчийн мэргэшил.

***Та хүмүүсийн дээгүүр зөвшөөрөл авахгүй нисэхийг хүсч байна уу?***

ИНД-101-ийн дагуу, үйл ажиллагаа эрхлэгчийг нислэгийн дор байх хүмүүсээс зөвшөөрөл аваагүй бол хүмүүсийн дээрх агаарын зайг ашиглахаас зайлсхийхийг шаарддаг. Энэ шаардлага нь хувийн өмч, нийтийн эзэмшлийн зам талбай хоёуланд хамаарна.

Зөвшөөрлийн журмын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг (журам 101.207(а)(1)), АС-101-1-ээс лавлах.

Ерөнхийдөө, хүмүүсийн зөвшөөрөлгүй тэдний дээгүүр нисэх нь аюултай үйл ажиллагаа байж болзошгүй. Дээгүүр нь нисэх гэж байгаа хүмүүсээс зөвшөөрөл авах нь боломжгүй, яагаад авах боломжгүй гэдэг тайлбараа та хүсэлтдээ тэмдэглэх хэрэгтэй.

Зөвшөөрөл авах шаардлагыг сулруулах, эсхүл хасах эсэхээ шийдэхдээ, харгалзан үзэх зүйлс:

- нислэг үйлдэх агаарын хөлгийн жин болон хэмжээ;
- агаарын хөлгийн конфигураци (далавчит эсрэгээр олон сэнст, эсхүл дирижабль)-(агаарын хөлгийн гулсах чадамж болон сэнсний ир нь хаалттай/хучаастай зэрэг асуудал онцгой хамааралтай болно);

- агаарын хөлгийн найдвартай байдал;
- удирдлагын системийн найдвартай байдал (болон аливаа хамааралтай систем);
- “гэртээ буцах” үйлдлийг оруулан системд ямар нэгэн эвдрэл гарсан тохиолдолд засах арга хэмжээ;
- системийн нөөц (жнь: хүлээн зөвшөөрөх автомат сэргээх шүхэр);
- агаарын хөлгийг ашиглахаар зорьж байгаа газарзүйн бүс;
- агаарын хөлгийг нисгэх өндөр(-үүд);
- үйл ажиллагаа эрхлэгчийн тэдгээрийн үйл ажиллагааны болон аюулгүй байдлын удирдлагын талаарх ойлголтыг бий болгох үүднээс өгөх аюулын бүртгэлийг авч үзэх.

Хэрэв үйл ажиллагааг зөвшөөрөлгүй гүйцэтгэхийг зөвшөөрсөн бол та үйл ажиллагаа нөлөөлж болох хүмүүст мэдэгдэх зохих алхмыг (гэрчилгээнд хавсаргасан нөхцөлийн дагуу) авах шаардлагатай хэвээр байна. Үүнд: сонины сурталчилгаа, шуудангийн хайрцагт мэдээлэл тараах, эсхүл нислэгийн тодорхой бүс, эсхүл төлөвлөсөн үйл ажиллагааны бүсийн орох хэсэгт тэмдэг хадах г.м мэдээллийн хэрэгслийг ашиглаж болно.

Бусад тохиолдолд, жнь: спортын арга хэмжээ, оролцогчдод болох гэж байгаа үйл ажиллагааны урьдчилсан анхааруулгыг билетний хэсэг болгон мэдэгдэж болох юм (эдгээр нислэгийг хүлээн зөвшөөрч байж орох нөхцөл тавьж болно).

***Та эд хөрөнгийн эзэмшигчээс зөвшөөрөл авахгүй дээгүүр нь нисэхийг хүсч байна уу?***

ИНД-101-ийн дагуу, өмч хөрөнгийн оршин суугч, эсхүл өмч хөрөнгийн эзэмшигчийн урьдчилсан зөвшөөрөлгүй, үйл ажиллагаа эрхлэгч өмч хөрөнгийн бүс дээгүүрх агаарын зайд удирдлагатай хүнгүй агаарын хөлгийг нисгэхээс зайлсхийх шаардлагатай.

Энэ шаардлага нь хувийн өмч, нийтийн эзэмшлийн зам талбай хоёуланд хамаарна.

Зөвшөөрлийг үл хөдлөх хөрөнгийн эзэмшигч, эсхүл оршин суугчаас авна. Амьдрал дээр энэ нь хувийн өмчийн хувьд тухайн өмчийг эзэмшигч, түрээслэгч, эсхүл төлөөлөгч болно. Нийтийн орон зайн хувьд, тухайн орон зайг эзэмшиж байгаа, эсхүл хянаж байгаа агентлаг, эсхүл байгууллагаас авна (жнь: орон нутгийн зөвлөл, эсхүл байгаль хамгаалах хэлтэс).

Тухайн нөхцөл байдлаас шалтгаалан зөвшөөрөл нь болзолт, эсхүл нээлттэй байж болно. Хэрэв байнгын зохицуулалт, эсхүл ойлголцол нь зөвшөөрөлд тусгагдсан бол нэг хүмүүсээс олон дахин зөвшөөрөл хүсэх шаардлагагүй байж болно.

Зөвшөөрөл нь өөрөө албан бус аман, бичгээр, эсхүл илүү албан ёсны гэрээгээр г.м олон төрлийн хэлбэртэй байж болно. Энэ нь тухайн нөхцөл байдал болон газар эзэмшигчийн шаардлага, оролцогч хүмүүс, мөн үйл ажиллагаа эрхлэгчийн арилжааны үйл ажиллагааны зайлшгүй шаардлагаас хамаарна.

Одоо байгаа гэрээ болон зохицуулалт нь тодорхой тохиолдолд хангалттай байж болно. Жнь: өмнө нь үйл ажиллагааны болзолт зөвшөөрөл өгөгдсөн газарт нэвтрэх, эсхүл дамжин өнгөрөх замаар эрх нь баталгаажсан арилжааны гэрээ.

Зөвшөөрлийн дүрмийн талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг (101.207(a)(1)) АС-101-1-ээс лавлах.

Зөвшөөрөл хүсэх нь хоёр үе шаттай үйл явц:

- (1) тухайн газар эзэмшигч, эсхүл өмчид оршин суугаа хүмүүс (эсхүл тэдний төлөөлөгчийг) эрж олох;
- (2) өмч хөрөнгөн дээр, эсхүл таны үйл ажиллагааны эргэн тойронд байгаа хүмүүсээс зөвшөөрөл хүсэх.

Хэрэв та дээгүүр нь нисэхийг зорьж байгаа өмч хөрөнгийн эзэмшигч, эсхүл өмч хөрөнгөнөөс зөвшөөрөл авах боломжгүй бол таньд ИНД-102-ын гэрчилгээ хэрэгтэй.

Таны зөвшөөрөл авах боломжгүй байх шалтгаан нь дараах байж болно:

- Зөвшөөрөл авах нь дараахаас болж төвөгтэй байна:
  - дээгүүр нь нисэх өмч хөрөнгийн тоо;
  - тухайн үйл ажиллагааны байрлал;
  - тухайн үйл ажиллагааны шинж чанар (жнь: онцгой нөхцөлийн үйлчилгээний хэрэглээ);
- өмч хөрөнгийн эзэмшигч, эсхүл төлөөлөгчийг олж чадахгүй байх;
- өмч хөрөнгийн эзэмшигчтэй холбоо тогтоох оролдлого бүтэлгүйтэх;
- өмч хөрөнгийн эзэмшигч зөвшөөрөл өгөх хүсэлгүй байх;
- хэн зөвшөөрөл өгөх ёстой, эсхүл эрхтэй нь тодорхойгүй байх.

Дээгүүр нь нисэх гэж байгаа хүмүүсээс зөвшөөрөл авах нь боломжгүй, яагаад авах боломжгүй болохыг та хүсэлтдээ тайлбарлах хэрэгтэй.

Зөвшөөрөл авах шаардлагыг сулруулах, эсхүл хасах эсэхээ шийдэхдээ, харгалзан үзэх зүйлс:

- нислэг үйлдэх агаарын хөлгийн жин болон хэмжээ;
- агаарын хөлгийн конфигураци (далавчит эсрэгээр олон сэнст, эсхүл дирижабль)-(агаарын хөлгийн гулсах чадамж болон сэнсний ир нь хаалттай/хучаастай зэрэг асуудал онцгой хамааралтай болно);
- агаарын хөлгийн найдвартай байдал;
- удирдлагын системийн найдвартай байдал (болон аливаа хамааралтай систем);
- “гэртээ буцах” үйлдлийг оруулан системд ямар нэгэн эвдрэл гарсан тохиолдолд засах арга хэмжээ;
- системийн нөөц (жнь:хүлээн зөвшөөрөх автомат сэргээх шүхэр);
- агаарын хөлгийг ашиглахаар зорьж байгаа газарзүйн бүс;
- агаарын хөлгийн үйл ажиллагаа гүйцэтгэх өндөр (үүд);
- үйл ажиллагаа эрхлэгчийн тэдгээрийн үйл ажиллагааны болон аюулгүй байдлын удирдлагын талаарх ойлголтыг бий болгох үүднээс өгөх аюулын бүртгэлийг авч үзэх.

Хэрэв үйл ажиллагааг зөвшөөрөлгүй гүйцэтгэхийг зөвшөөрсөн бол та үйл ажиллагаа нөлөөлж болох хүмүүст мэдэгдэх зохих алхмыг (гэрчилгээнд хавсаргасан нөхцөлийн дагуу) авах шаардлагатай хэвээр байна. Үүнд сонины сурталчилгаа, шуудангийн хайрцагт мэдээлэл тараах, эсхүл нислэгийн тодорхой бүс, эсхүл төлөвлөсөн үйл ажиллагааны бүсийн орох хэсэгт тэмдэг хадах г.м мэдээллийн хэрэгслийг ашиглаж болно.

Хэрэв та зөвшөөрөл авахын бол, орон нутгийн засаг захиргааны байгууллагын тогтоол шийдвэр болон шаардлагыг багтаасан бусад бүх холбогдох хууль тогтоомжийг дагах мөрдөх нь хамгийн чухал.

Хэрэв та камер, эсхүл бусад ижил төрлийн технологийг ашиглаж байгаа бол Хувь хүний нууцын тухай хуулийг дагах ёстой.

### ***Та хөдөө аж ахуйн нислэг явуулахыг хүсч байна уу?***

Хөдөө аж ахуйн зорилгоор хүнгүй агаарын хөлгийг нисгэх нь газарт их доогуур нисч, аюултай материал хэрэглэдэг, мөн бусад доогуур нисч байгаа агаарын хөлгийн ойролцоо нисэх тул аюул учирч болзошгүй.

ИНД-137 “Хөдөө аж ахуйн зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт” нь хүнтэй агаарын хөлгийн хөдөө аж ахуйн үйл ажиллагааг зохицуулж байгаа хүчинтэй Дүрэм. Энэ нь таны санал болгож байгаа аюулгүй байдлын шаардлагыг харгалзан үзэхэд ашиглах хэрэглээний хэсэг юм. ИНД-137-ийн үйл ажиллагаанд нөлөөлөх нөхцөлийг ИНД-102-ын гэрчилгээнд зааж болно.

Жнь: таны үйл ажиллагаатай холбоотой ажилтныг хөдөө аж ахуйн болон химийн зэрэглэл эзэмшихийг тэдний гэрчилгээний нөхцөлд шаардсан байж болно. Химийн бодисыг хэрэглэх нь үйл ажиллагаа эрхлэгчийг бусад үр тариа, эсхүл өмч хөрөнгөнд цацах бодисын чадамж болон түүнд учрах санамсаргүй хохирлын талаар мэдэж байхыг шаарддаг.

### ***Хүсэлт болон Ерөнхий заавраа бэлдэх нь***

Аливаа хүнгүй агаарын хөлгийн үйл ажиллагаа нь зохицуулалт шаардлагатай аюул болон эрсдэлийг дагуулна. Энэ нь үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэг хариуцлага болохоор та энэ талаар сайн бодох ёстой.

Аюулын бүртгэлийг бий болгох нь бүх болзошгүй аюул, аюул бүрээс гарах эрсдэлийн түвшин болон эдгээр эрсдэлийг бууруулах арга хэмжээний талаар та мэдэж байгааг харуулах чухал зүйл юм.

Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэхээр гэрчилгээ эзэмших хүсэлт гаргахдаа та үйл ажиллагаа аюулгүй байхыг батлан үзүүлж чадах ёстой. Дарга үйл ажиллагаанд оролцох хүмүүс, агаарын хөлөг болон тухайн үйл ажиллагааны цар хүрээг судална. Гэрчилгээ олгохын өмнө үйл ажиллагаа аюулгүй, үйл ажиллагаа эрхлэгч эрсдэлийг бууруулах болон хянах чадвартай гэдэгт Дарга сэтгэл хангалуун байх ёстой.

Санал болгож байгаа үйл ажиллагааны аюулгүй байдлыг харуулахын тулд үйл ажиллагаа эрхлэгч нь стандарт үйл ажиллагааны журмын (SOP) багцыг бий болгож, баримтжуулах Ерөнхий заавартай байх шаардлагатай. Стандарт үйл ажиллагааны

журамд үйл ажиллагааны төрөл болон үйл ажиллагаа гүйцэтгэхээр зорьж байгаа байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийх процессыг багтаасан байх ёстой. Стандарт үйл ажиллагааны журам нь үйл ажиллагаа эрхлэгч хяналт тавьдаг байгууллагын энгийн зааврын хэлбэртэй байх ёстой. Үүнийг энэ АС-д тусгасан 102.11(b)(10)-аас лавлах.

Үйл ажиллагаа эрхлэгчид байгууллагын аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлэхийг шаргуу зөвлөдөг. Жижиг, түвэгтэй бус байгууллагын (SMS)-ийг бий болгох талаарх мэдээлэл ИНЕГ-ын веб хуудас [www.mcaa.gov.mn](http://www.mcaa.gov.mn) [гол хуудсан дах SMS холбоосыг дагах], эсхүл UK ИНЕГ-ын веб сайтаас үзэж байна.

Ерөнхий зааврыг бэлтгэх явцдаа, та ИНД-ийн бусад зүйл, заалтын шаардлагыг (жнь: ИНД-91 “Нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм”-ээс зарим шаардлага, эсхүл хөдөө аж ахуйн үйл ажиллагааны хувьд ИНД-137 “Хөдөө аж ахуйн зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт”) оруулахыг хүсч болно. Энэ нь Даргад тухайн үйл ажиллагаа нь аюулгүй байдлын хамгийн боломжит өндөр стандартын дагуу хийгдэх болно гэсэн баталгааг гаргаж өгнө.

### **102.9 Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэхээр гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах**

ИНД-102-ын дагуу гэрчилгээжих шаардлагатай, эсхүл хүсэлтэй үйл ажиллагаа эрхлэгч нь САА24102/01 маягтаар ИНЕГ-т хүсэлт гаргах үүрэгтэй. Хүсэлтийн маягтыг ИНЕГ-ын вебсайт ([www.mcaa.gov.mn](http://www.mcaa.gov.mn)) Маягт гэсэн хэсгээс авч болно.

Хүсэлтийн маягт нь нилээд дэлгэрэнгүй байна. Энэ нь хийж болох олон төрлийн өөр өөр үйл ажиллагааг багтаах шаардлага байгаатай холбоотой. Хэрэв таны үйл ажиллагаа харьцангуй энгийн бол та бүх хэсгийг бөглөх шаардлагагүй болохоо олж мэднэ. Үүнийг ИНЕГ-ын ажилтантай зөвшилцөн тодорхойлж болно. Та илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгөхийн бол ИНЕГ-аас хүсэлтэд үнэлгээ хийхэд хялбар байх ба үр дүнд нь цаг хугацаа багасах болно.

Та ИНД-102-ын дагуу хүсэлт гаргахаар төлөвлөж байгаа бол санал болгож байгаа үйл ажиллагааны хамрах хүрээ болон хүсэлт гаргах шаардлагыг хэлэлцэх гэрчилгээжүүлэлтийн өмнөх уулзалтыг зохион байгуулахаар ИНЕГ-тай холбоо барина. Энэ нь төлбөргүй болно.

#### ***Бид юунд үнэлгээ хийх вэ?***

ИНЕГ нь энэхүү үнэлгээг хийх баримт бичгийг гарын авлага болгон таны Ерөнхий зааврыг ашиглан санал болгож байгаа үйл ажиллагааг бүхэлд нь хянана.

Түүнчлэн, таны аюулын бүртгэл нь та өөрийн үйл ажиллагаатай холбоотой бүх аюулыг ойлгож, аливаа хамааралтай эрсдэлийг удирдах, эсхүл багасгах арга хэмжээг авч байгаа гэдгийг харуулах түлхүүр болно.

### **102.11 Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн Ерөнхий заавар**

Хэрэв та хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргахыг хүсвэл та санал болгож байгаа үйл ажиллагаатай холбоотой олон чухал асуудлыг багтаасан Ерөнхий зааврыг танилцуулах шаардлагатай.



Ерөнхий заавар гэдэг нь үйл ажиллагаа эрхлэгч аюулгүй байдлын шаардлагатай түвшинг хадгалах болон дүрмийн нийцлийг хэвээр байлгахын тулд өөрийн үйл ажиллагааг хэрхэн гүйцэтгэх талаарх тодорхойлолт юм.

Танд туслах зорилгоор ИНЕГ нь ИНД-102-ын нийцлийн матрицыг (САА24102/03) зохиосон. Энэхүү баримт бичиг нь дүрмийн шаардлага бүрийг тодорхойлж, тухайн дүрмийн тодорхой заалтын биелэлтийг харуулах зорилготой хүсэлт гаргагч Ерөнхий заавартаа тусгай хэсэг/зүйлийг тодорхойлох хоосон зайтай. Матриц нь тухайн хүсэлтийг дэмжих бөгөөд ИНЕГ-ын үнэлгээний явцад ихээхэн ач холбогдолтой, цаг хугацаа болон зардал хэмнэх боломжийг олгодог.

Дүрмийн заалт бүрийн эсрэг хэсэг болон/эсхүл зүйлийн лавлагааг тодорхойлох нь таны хувьд хамгийн зөв арга юм. Энэ нь тухайн Ерөнхий зааварт хэрэгтэй хэсэг/зүйлийн дугаарлалтын системийг дагадаг. Үүнээс гадна, Ерөнхий зааврын хяналтын хувьд, хуудасны дугаарлалт, гарсан огноо, хүчинтэй хуудасны жагсаалт (LEP) болон гарчиг хуудас мөн хэрэгтэй. Нийцлийн матрицын танилцуулга хуудсанд энэ талаарх нэмэлт зааварчилгаа бий.

### **102.11(b) Ерөнхий зүйл:**

Энэ дүрэм нь Ерөнхий зааварт орох шаардлагатай шаардлагыг заасан. Сайн бичсэн, дэлгэрэнгүй Ерөнхий заавар нь ИНЕГ-аас таны хүсэлтийг үнэлэхэд тусална, ялангуяа хэрэв үйл ажиллагааны журмыг өөрийн үгээр тодорхой тайлбарласан байвал.

Дарга санал болгож байгаа үйл ажиллагааны тодорхой нөхцөл байдал, агуулга болон шинж чанараас хамааран эдгээр шаардлагаас заримыг нь шаардах эрхтэй. Энэ нь танаас юу хүлээж болох талаар хэлэлцэх гэрчилгээжүүлэлтийн өмнөх уулзалт чухал болохыг онцолж байна.

### **102.11(b)(1) Үндсэн үүрэг хариуцлага хүлээх этгээд:**

Энэ дүрэм нь танаас “Гол Хүн”-ээ тодорхойлохыг шаарддаг. Энэхүү онцлох үгнээс харахад энэ хүн нь үйл ажиллагааг голлон удирддаг бөгөөд ерөнхийдөө анхны хүсэлтийг гаргадаг этгээд болно. Ихэнхдээ энэ хүн үйл ажиллагааг санхүүжүүлэх болон нөөцөөр хангах үүрэгтэй (агаарын хөлөг багтана). Тухайн үйл ажиллагааны аль нэг хэсгийг хариуцахаар тодорхойлогдсон хүмүүсийн хоорондох үүрэг хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан жижиг байгууллагын бүтцийн зураг (гэр бүлийн модтой төстэй)-ыг гаргасан байх ёстой. Эзэмшигч/үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагааны хувьд энэ нь харьцангуй энгийн боловч томоохон байгууллагын хувьд тодорхой үүрэг, хариуцлагын шугам байх ёстой.

Гол хүн нь мөн тохирох, зөв хүний үнэлгээтэй хамааралтай этгээд болно. Тохирох, зөв хүн үнэлгээний талаарх нэмэлт мэдээллийг энэ АС-д сүүлд оруулсан.

### **102.11(b)(2) Хяналт тавих этгээд:**

Энэ дүрэм нь үйл ажиллагааны аль ч хэсэгт хяналт тавих этгээдийг тодорхойлохыг шаардана. Энэ этгээд нь нислэг, эсхүл сургалтад хяналт тавих боломжтой, эсхүл техник үйлчилгээнд хяналт тавих үүрэгтэй байна. Гэр бүлийн модыг ашиглах нь үүрэг

хариуцлагын шугаман хамаарлыг харуулах бөгөөд гол хүнд эргэн тайлагнах боломжтой болно.

#### **102.11(b)(3) Үйл ажиллагааны бүс:**

Энэ дүрэм нь танаас RPAS-аар үйл ажиллагаа гүйцэтгэх бодит бүсийг тодорхойлохыг шаардана. Зарим тохиолдолд та тухайн бүсийг гудамжны нэрээр тогтоох боломжтой. Бусад тохиолдолд тухайн бүсийг тэмдэглэсэн газрын зураг нь хамгийн зөв шийдэл байж болно.

“Монгол Улсад”, эсхүл бусад том тодорхой бус газарзүйн бүсэд үйл ажиллагаа гүйцэтгэх зөвшөөрөл хүсэх боломжтой тохиолдолд, үйл ажиллагаа эрхлэгч нь аливаа орон нутгийн агаарын зайн хязгаарлалт болон/эсхүл бусад орон нутгийн шинжтэй үйл ажиллагааны нөхцөлийг мэдэж байгааг бататгах ажлыг хэрхэн гүйцэтгэхийг төлөвлөх хэрэгтэй.

#### **102.11(b)(4) Аюулын бүртгэл:**

Энэ дүрэм нь танаас аюулын бүртгэл хөтлөхийг шаардана. Энэ бүртгэл нь үйл ажиллагааны эрсдэлд тохирсон, зохих залруулах арга хэмжээг тодорхойлсон байна. Аюулыг таньж тогтоох болон холбогдох эрсдэлийг удирдах баримтжуулсан аргыг оруулах нь зорьж байгаа үйл ажиллагаа эрхлэгч тухайн үйл ажиллагааныхаа агуулгыг ойлгож, аюулгүй байдлын хамгийн сайн үр дүнд хүргэх стандартыг хэрэгжүүлж байна гэдэг итгэл төрнө. Мэдээллийг хэрхэн цуглуулах, удирдах төлөвлөгөөгөө хэрхэн хуваарилах болон ажилтанд учирч болзошгүй аюулыг бууруулах үүнд аливаа аюулыг бууруулах тэдний үүргийг анхаарах хэрэгтэй.

Аюулыг үнэлэх үйл явц нь хөөрөлт болон буулт үйлдэхтэй холбоотой аюулыг багтаан, үйл ажиллагааны бүх үе шатыг хамарсан байх ёстой.

#### **102.11(b)(5) Мэдээлэл өгөх:**

Дүрэм танаас осол, зөрчлийг мэдээлэх журамтай байхыг шаарддаг

Одоогоор хүнтэй агаарын хөлөгт тавих мэдээлэх шаардлагыг дэлгэрэнгүй заасан ИНД-12 нь хүнгүй агаарын хөлөгт хамаарахгүй. Дарга харин тухайн тохиолдол бүрд үндэслэн тусгай мэдээлэх ерөнхий бүтцийг гаргаж өгөх боломжтой.

Зорилгод тохирсон мэдээлэх механизмтай болох хүртэл үйл ажиллагаа эрхлэгч нь ИНД-12-т нийцсэн аргачлалаар осол, ноцтой зөрчлийг мэдээлэх шаардлагатай.

CAA005 Occurrence report ([http://www.mcaa.gov.mn/Forms/CA005\\_Form](http://www.mcaa.gov.mn/Forms/CA005_Form))-ийг мэдээлэх механизм болгон ашиглана. Энэ маягтын ихэнх хэсэг нь хамаарахгүй байж болно (тийм тохиолдолд тэдгээрийг хоосон орхино), гэхдээ тухайн маягтыг ашиглах нь ИНЕГ-ын мэдээлэх системийн нийцлийг хангах болно.

Та ерөнхийдөө дараах төрлийн үйл явдлыг мэдээлэх шаардлагатай:

- хүн гэмтэх;
- удирдлага алдагдах;
- fly-away;
- хөдөлгүүр, эсхүл бүтцийн доголдол;

- хүнтэй агаарын хөлөгтэй холбоотой зөрчил;
- зөвшөөрөлгүй агаарын зайд нэвтрэх;
- гуравдагч этгээдийн өмч хөрөнгийн хохирол.

Хэрэв та мэдээлэх эсэхээ мэдэхгүй байгаа бол, мэдээлэх тал дээр алдаа гаргаж болзошгүй болохыг зөвлөж байна.

Танаас, хүнгүй агаарын хөлгийн найдвартай байдлыг тогтоох зорилгоор ИНЕГ-ыг өгөгдлөөр хангадаг зөрчлийн мэдээлэлтэй холбогдох үедээ тогтмол статистикийн мэдээлэл гаргаж өгөхийг шаардаж болно. Цуглуулсан илүү их мэдээлэл нь хүнгүй агаарын хөлгийн үйл ажиллагаанд хамаарах хязгаарлалтыг хянах бодлогын ажлыг мэдэгдэх найдвартай байдлыг хурдан олж авах боломжтой.

### **102.11(b)(6) Үнэмлэхжүүлэлт болон мэргэшил:**

Энэ дүрэм нь ажилтны үнэмлэх, мэргэшил, сургалт болон ур чадварт тавих үйл ажиллагааны шаардлагатай холбоотой. Одоогоор хүнгүй агаарын хөлгийн чадамж, мэргэшлийн шаардлагыг олон улсад хүлээн зөвшөөрсөн стандарт байхгүй байна. Мөн, Монгол Улсын ИНД нь RPAS-ийн үйл ажиллагааны тодорхой шаардлагыг тусгаагүй болно.

Дүрэмд Дарга мэдлэг болон ур чадварын үндсэн хоёр чиглэлээр сэтгэл ханамжтай байхыг заасан:

- (1) нисэхийн ерөнхий мэдлэг (агаарын зай болон агаарын тухай хуулийг багтаасан);
- (2) алсын удирдлагатай агаарын хөлөг/хүнгүй агаарын хөлгийн (агаарын хөлгийн буултыг/ ашиглалтыг багтаасан) тодорхой мэдлэг.

Тухайн үйл ажиллагаанд оролцох ажилтнаас шаардаж болох мэргэшил болон/эсхүл мэдлэгийг үнэлэхдээ ИНЕГ тухайн хүний мэдлэг болон ур чадварт сэтгэл ханамжтай байх шаардлагатай. Ерөнхийдөө мэргэшлийн, эсхүл нисгэгчийн үнэмлэх нь үүний нотолгоо байх болно.

Бүх үнэлгээг тухайн хүний гүйцэтгэх дараах үүрэг, болон оролцох үйл ажиллагааны үндсэн шинж чанар, хамрах хүрээнд хийнэ:

- агаарын хөлгийн даргын;
- удирдлагын станцын ажилтны;
- ажиглагчийн.

### **Агаарын хөлгийн дарга болон удирдах хүмүүс**

ИНД-102-ын гэрчилгээгээр RPAS-ийн удирдах этгээд болон/эсхүл агаарын хөлгийн даргаар зөвшөөрөгдөхийн тулд, тухайн хүн нь нисэхийн ерөнхий мэдлэг болон RPAS-ийн тусгай ур чадварыг эзэмшсэн байна.

Үйл ажиллагааны шинж чанар болон хамрах хүрээ нь өөрөөр шаардаагүй бол, нисэхийн ерөнхий мэдлэгээ дараах зүйлээр харуулахыг хүлээн зөвшөөрнө:

- ИНД-61-ийн дагуу олгосон нисгэгчийн үнэмлэх, эсхүл ИНД-149-ийн байгууллагаас олгосон нисэх клубын хэт хөнгөн агаарын хөлгийн, эсхүл глайдерын нисгэгчийн үнэмлэх;

- Дарга хүлээн зөвшөөрөхүйц, гадаадын нэр хүндтэй нисэхийн байгууллагаас олгосон зайнаас удирддаг агаарын хөлгийн үнэмлэх (эсхүл түүнтэй дүйцэх бичиг баримт):
- хувийн нисгэгчийн үнэмлэхний (PPL) нисэхийн хууль, дүрмийн шалгалтад тэнцсэн; нислэгийн радио-холбооны операторын (FRTO) шалгалт; нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл 2; агаарын зай болон нислэгийн радионы хэрэглээнд үндэслэсэн таван цагийн агаарт гарсан туршлага:
- ИНД-141-ийн сургалтын байгууллагаас олгосон дараах шаардлагыг харуулж байгаа амжилтын гэрчилгээ:
  - нисэхийн хууль, дүрмийн онолын шалгалтад тэнцсэн;
  - хүнгүй агаарын хөлгийг ажиллуулах чадвар;
  - нисэхийн радиог ашиглах ур чадвар (хэрэв хамааралтай бол).

Үйл ажиллагааны шинж чанар, хамрах хүрээ нь өөрөөр шаардаагүй бол RPAS-ийн тусгай ур чадвараа дараах зүйлээр харуулахыг хүлээн зөвшөөрнө:

- хүнгүй агаарын хөлгийн төрөлд хамаарах Монгол улсын Загварын Нислэгийн далавчны тэмдэг (ж нь: далавчит, нисдэг тэрэг, олон сэнст):
- үйл ажиллагаа гүйцэтгэх хүнгүй агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн зохион байгуулсан сургалтын гэрчилгээ (эсхүл түүнтэй дүйцэх бичиг баримт):
- хүнгүй агаарын хөлгийн сургалт явуулах эрхтэй ИНД-141-ийн сургалтын байгууллагын зохион байгуулсан сургалтын гэрчилгээ.

Бид RPAS-ийн сургалтын курс зохион байгуулдаг байгууллагын тоо нэмэгдэнэ гэж бодож байна. Хүлээн зөвшөөрөгдөхийн тулд үйл ажиллагаа эрхлэгч нь хичээлийн хөтөлбөрийн хувийг олж авч нийлүүлэх шаардлагатай бөгөөд үүнийг ИНЕГ-аас авч үзэх болно.

Үйл ажиллагаанд оролцох бусад ажилтны хувьд, ИНЕГ хүсэлт бүрийг давуу талаас нь авч үзнэ.

Ерөнхий зааварчилгааг дор тусгав.

### **Ажиглагч / багийн бусад гишүүн**

Ажиглагч нь энгийн засаж залруулж болох (жнь: зааврын дагуу шилтэй) хараатай байхаас бусдаар хараа, эсхүл сонсголын талын, өөр ямар нэг эмгэггүй байх ёстой.

Үйл ажиллагааны шинж чанар, хамрах хүрээ нь өөрөөр шаардаагүй бол ажиглагч нь ерөнхийдөө хамгийн багадаа дараах чиглэлээр ур чадвараа харуулах ёстой:

- нисгэгчтэй шууд харьцах арга;
- харилцаа холбоо амжилтгүй болсон тохиолдолд авах арга хэмжээ болон нөөц арга хэмжээ;
- тэнгэрийг секторт хуваах арга зам, ингэснээр аливаа зөрчигчийн байршлыг шууд мэдэгдэх тэр үед нисгэгчид мөн мэдээлэл очно;
- аливаа үйл явдал болоход онгоцноос гарах онцгой нөхцөлийн журам.

Олноор цугласан хүмүүсийг хянах үүрэгтэй багийн бусад гишүүн нь үйл ажиллагаа эрхлэгчээс сургалт авч, зөвшөөрөлтэй болсон гэдгээ үзүүлэх ёстой. Багийн бусад гишүүн нь тохирох, сайн харагдахуйц хүрэм өмсөнө.

Гэрчилгээ авсны дараа ажиглагч болон багийн бусад гишүүн нь үйл ажиллагаа эрхлэгчийн сургалтад хамрагдаж, бичгээр зөвшөөрөл авсан байна. Аливаа байнгын сургалтын бүртгэл болон тусгай ажлын талбайн зөвшөөрлийг үйл ажиллагаа эрхлэгч болон холбогдох багийн гишүүн хадгална.

### **Нислэгийн цагийн бүртгэл болон үйл ажиллагааны туршлага**

Дагаж мөрдөх хэлбэр нь зөвхөн зөвлөмж зааварчилгаа юм. Үүнийг ИНД-102-ын гэрчилгээний нөхцөл болгон заагаагүй тохиолдолд заавал дагаж мөрдөх шаардлагагүй.

Нисгэгч болон бусад холбогдох хүмүүс нь өөрсдийн нислэгийн цаг болон үйл ажиллагааны туршлагаа бүртгэх бүртгэлийн дэвтрийг хөтлөх ёстой. Бүртгэлийн дэвтэрт наад зах нь дараах мэдээллийг оруулна:

- нисгэгч/багийн гишүүний нэр;
- агаарын хөлгийн маяг болон серийн дугаар (хэрэв байдаг бол);
- нислэгийн цаг;
- нислэгийн зорилго;
- нислэгийн үр дүн;
- үйл ажиллагааны нислэг, эсхүл сургалтын нислэгийн дэлгэрэнгүй.

Бүртгэлийн дэвтэр нь цаасан, эсхүл цахим хэлбэрээр байж болох боловч Даргын хүсэлтээр гаргах боломжтой байх ёстой.

Эдгээр бүртгэлийг хөтлөх нь зайлшгүй биш хэдий ч хатуу зөвлөдөг ба ИНД-102-ын гэрчилгээг сунгуулах болон/эсхүл одоо байгаа гэрчилгээний дагуу үйл ажиллагааны хамрах хүрээг өөрчлүүлэх, эсхүл өргөжүүлэх хүсэлт гаргах үед хэрэгтэй болно.

### **102.11(b)(7) Ашиглах агаарын хөлгийн дэлгэрэнгүй:**

ИНЕГ нь хүсэлтийн хамт ирүүлсэн дараах мэдээллийг үзэх болно:

- агаарын хөлгийн хэлбэр (роторт хөлөг/ далавчит);
- хэмжээс болон жин (нисэхэд бэлэн);
- агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн таних тэмдэг, эсхүл хэрэв a homebuilt RPAS бол барьсан хүн, цаг хугацааг тогтоох;
- аливаа дагалдах хэрэгсэл, эсхүл суурилуулсан role equipment;
- агаарын хөлгийн анхдагч болон хоёрдогч өнгийг багтаасан өвөрмөц тэмдэглэгээ, эсхүл таних тэмдэг.

Хэрэв Дарга 102.13(b)(3)-ыг зохих ёсоор анхаарч үзээд ИНД-47-гийн дагуу тэмдэглэгээ хийхийг шаардвал, зааварчилгааг AC47-1 [www.mcaa.gov.mn](http://www.mcaa.gov.mn)-аас олж авна.

Хэрэв ИНД-47-г биелүүлэх шаардлагагүй бол, үйл ажиллагаа эрхлэгчийг тодорхой илэрхийлэх байнгын маркер/шошго ашиглан агаарын хөлгийг тэмдэглэх ёстой гэж үзнэ.

Агаарын хөлгийн хэмжээ, эсхүл шинж чанараас шалтгаалан өөрөөр шаардсанаас бусад тохиолдолд, ИНЕГ нь тухайн агаарын хөлгийг үйл ажиллагаа эрхлэгчийг таниулахаар тэмдэглэсэн байх ёстой гэж үзнэ. Тэмдэглээг аливаа хучаасыг авалгүй

уншиж болохоор байршилд байрлуулна. Маркны хэмжээ нь агаарын хөлгийн хэмжээтэй тохирсон хэмжээтэй байна.

#### **102.11(b)(8) Удирдлагын систем:**

Энэ дүрэм нь удирдлагын системийг таниулж, зөвшөөрүүлэхийг шаардана. Одоогийн байдлаар хүнгүй агаарын хөлгийн удирдлагын системд хамаарах олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн загварын стандарт, эсхүл конфигурацийн шаардлага байхгүй.

Удирдлага болон хяналтын шугам нь нислэгийг удирдах зорилгоор RPA болон түүний алсын удирдлагын станц хоорондын өгөгдлийн холболтыг хэлнэ. Энэ чиглэлээр стандарт боловсруулахаар Аэронавигацийн Радио Техникийн Комиссоос (RTCA) олон улсын хэмжээнд ажил явуулж байгаа боловч дуусах болоогүй байна.

Хэсэг хугацаанд, түгжрэл, эсхүл бусад хөндлөнгийн оролцоог багтаан, C2 холбоосны найдвартай байдлын талаар болгоомжтой байх шаардлагатай. Ийм учраас, энэ технологийг ашиглаж байгаа том хүнгүй агаарын хөлгийг, үйл ажиллагаа эрхлэгч эдгээр асуудлыг шийдсэн гэдгээ харуулж чадах хүртэл зөвшөөрөхгүй байх магадлалтай.

Монгол Улсад үйл ажиллагаа гүйцэтгэх боломжтой хүнгүй агаарын хөлгийн хувьд C2 холбоосны үнэлгээг үйл ажиллагааны түүхэнд үндэслэн хийнэ. Үйл ажиллагааны сайн түүхийг тухайн RPAS-ийн загвар/маягийг ашиглахыг тодорхойлоход хэрэгтэй.

#### **102.11(b)(9) Агаарын хөлгийн техник үйлчилгээ:**

Энэ дүрэм нь танаас өөрийн ашиглаж байгаа бүх агаарын хөлөгт тохирох Даргын хүлээн зөвшөөрөхүйц техник үйлчилгээний хөтөлбөр боловсруулахыг шаардана. Техник үйлчилгээний хөтөлбөр нь агаарын хөлөгт хамаарах үйл ажиллагааны шинж чанар, агаарын хөлгийн хэмжээ, нарийн төвөгтэй байдлыг тусгасан байна. Энэ хөтөлбөр нь үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний зааварчилгаанд суурилсан байх бөгөөд дараах зүйлийг зайлшгүй багтаана:

- нислэгийн өмнөх үзлэгийн зааварчилгаа, эсхүл шалгах хуудас;
- нислэгийн дараах үзлэгийн зааварчилгаа, эсхүл шалгах хуудас;
- үечилсэн (жнь: тогтмол) хуваарьт үзлэг шалгалтын хуваарь;
- аливаа бүрдэл хэсгийн хязгаар, эсхүл ашиглалтаас гарах дэлгэрэнгүй мэдээлэл;
- үйлчилгээний мэдээлэл, эсхүл НТЧ-ын удирдамжтай холбоотой арга хэмжээ;
- агаарын хөлгийн ТҮ хариуцсан этгээд;
- эвдрэлийн зөвшөөрөгдөх үзүүлэлт (жнь: сэнс г.м бүрдэл хэсгийг өөрчлөх ёстой үед).

Бүх техник үйлчилгээний үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллийг агаарын хөлгийн бүртгэлийн дэвтэрт хөтөлсөн байх нь зүйтэй.

Дараах зүйл нь ИНД-102-ын гэрчилгээний дагуу хүлээн зөвшөөрч болох техник үйлчилгээний гүйцэтгэлийн түвшинг дүрсэлсэн.

### **Том хүнгүй агаарын хөлөг**

Том хүнгүй агаарын хөлгийн хувьд ИНД-66-аар мэргэшсэн, зэрэглэлтэй, үнэмлэхтэй агаарын хөлгийн техник үйлчилгээний инженерийн (LAME) гүйцэтгэсэн техник үйлчилгээг ерөнхийдөө хүлээн зөвшөөрнө. ИНД-145-ын агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагаас гүйцэтгэсэн техник үйлчилгээг мөн хүлээн зөвшөөрөх болно.

Том хүнгүй агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс гүйцэтгэсэн техник үйлчилгээг хүлээн зөвшөөрөх боловч үйлдвэрлэгчээс ашигласан аливаа техник үйлчилгээний хөтөлбөрийн нотлох баримтыг зөвшөөрөл хүсэхдээ өгөх хэрэгтэй. Том хүнгүй агаарын хөлгийн үйлдвэрлэгч нь үйл ажиллагаа эрхлэгчид техник үйлчилгээний дэмжлэг болон сургалт өгч болно; агаарын хөлөгт тодорхой техник үйлчилгээ гүйцэтгэхийг зөвшөөрөх сургалтын нотлох баримтыг та өгөхийг хүсч болно.

Нисгэгчгүй, НТЧ-ын гэрчилгээ авсан байх агаарын хөлөг нь ИНД-21-ийн дагуу заасан стандарт гэрчилгээний явцыг мөрдөх шаардлагатай.

### **Дунд болон жижиг хүнгүй агаарын хөлөг**

Дунд болон жижиг хүнгүй агаарын хөлгийн техник үйлчилгээг ерөнхийд нь үйл ажиллагаа эрхлэгчийн хариуцах үүрэг гэж үздэг.

Дунд болон жижиг хүнгүй агаарын хөлгийн үйлдвэрлэгч нь үндсэн техник үйлчилгээний зааварчилгааг зөвхөн гарын авлага, эсхүл зааварчилгааны гарын авлага хэлбэрээр өгнө. Үйл ажиллагаа эрхлэгч нь үйл ажиллагааны зааврын удирдамж, болон техник үйлчилгээний хөтөлбөр болон Ерөнхий зааварт байгаа хязгаарлалтыг заах ёстой.

### **Зай хураагуурын техник үйлчилгээ**

Зай хураагуурын техник үйлчилгээ нь бүхээг цахилгаан ашигладаг, цахилгаанаар ажилладаг, эсхүл уламжлалт механикжсан хүнгүй агаарын хөлгийн аль алинд чухал. Үйл ажиллагаа эрхлэгч нь гүйцэтгэлийг ажиглах болон зай хураагуурын багц нурахаас өмнө харуулах болон үйлчилгээний багцаас салгах зэрэг зай хураагуурын багцтай холбоотой засвар үйлчилгээний сайн туршлагыг нэвтрүүлэх ёстой. Лити полимер ('LiPo') зай хураагуурын техник үйлчилгээг болгоомжтой ажиглаж, хүндэтгэлтэй хандахгүй бол маш аюултай байж болно.

LiPo зай хураагуурыг үйл ажиллагааны талбай руу тээвэрлэхдээ аюултай барааг ачих болон тээвэрлэх хамгийн сайн туршлагыг дагаж, аюулгүй сав ашиглах зэрэг санал болгож байгаа бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.

### **102.11(b)(10) Үйл ажиллагааны журам:**

Энэ дүрэм танаас санал болгож байгаа нислэгтэй холбоотой бүх үйл ажиллагааны журмыг баримтжуулах ёстой гэж шаарддаг. Үүнд дараах зүйл багтах ба, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй:

- та цаг уурын хязгаарлалтыг хэрхэн тогтоох вэ;
- та нисгэгчийн хувьд, агаарын хөлгийг хэрхэн ажиллуулах вэ;
- камер оператор болон ажиглагчдын хоорондох холбоос;

- агаарын хөлгийн нислэгийн өмнөх бэлтгэл;
- ажилтнуудын хоорондох харилцаа холбоо;
- хүн болон/эсхүл өмч хөрөнгө хүртэлх минимум зайг хэрхэн бататгах вэ.

Хүнтэй агаарын хөлгийн үйл ажиллагаанд эдгээрийг “үйл ажиллагааны стандарт журам” (SOPs) гэж нэрлэдэг, энэ нь ашиглахад тохиромжтой нэр томъёо юм. Нэмэлт зөвлөгөөг энэхүү АС-ын нүүрэн хэсгийн эхний зааварчилгаа материалаас үзнэ үү.

Үйлдвэрлэгчийн үйл ажиллагааны гарын авлага болон аливаа тогтоосон хязгаарлалт нь үйл ажиллагааны журмыг тогтоох хамгийн хэрэгтэй эхлэх цэг болно.

#### **102.11(b)(11) Ачаа тээвэрлэх болон эд зүйлийг агаараас хаях:**

Энэ дүрэм нь ачаа тээвэрлэх, эсхүл эд зүйл агаараас хаяхтай холбоотой үйл ажиллагааны нэмэлт конфигурацитай болгох / мөрдүүлэх зорилготой. Үйл ажиллагаа эрхлэгч нь ачаа зөөх, эд зүйл агаараас хаях, эсхүл хөдөө аж ахуйн үйл ажиллагаа, эсхүл үүнтэй ижил төрлийн үйл ажиллагаа гүйцэтгэхээр зорьж байгаа бол, тухайн үйл ажиллагаа нь хүн, эсхүл өмч хөрөнгөнд хохирол учруулахгүй байхыг бататгах журмыг тогтоох үүрэгтэй. Эдгээр журмыг мөн эрсдэлийн үнэлгээний үйл явцын эсрэг шалгаж үзэх ёстой. Тогтоосон журмыг SOPs-т нэмж оруулна.

#### **102.11(b)(12) Хүнгүй агаарын хөлгийг зохион бүтээх болон загвар:**

Одоогоор хүнгүй агаарын хөлөгт хамаарах, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн загварын стандарт, конфигурацийн шаардлага, эсхүл НТЧ-ын гэрчилгээ байхгүй. АНУ-д ASTM компани нь жижиг хүнгүй агаарын хөлгийн загварын стандарт дээр ажиллаж байна. Зарим анхан шатны стандартыг боловсруулсан бөгөөд эндээс үзэж болно.

Эдгээр стандарт нь зорьж байгаа үйл ажиллагаа эрхлэгчийг сайн зааварчилгаа материалаар хангах бөгөөд агаарын хөлгийн сонголтод туслах болно.

ИНЕГ нь нөхцөл байдлыг үнэлэх бүрдээ НТЧ-ын эхний үнэлгээг хийнэ. ИНЕГ-ын үнэлгээ нь агаарын хөлгийг зохих стандарт, эсхүл түвшинд боловсруулж, бүтээсэн эсэх болон гүйцэтгэхээр санал болгож байгаа үйл ажиллагаа, ашиглах төхөөрөмж, эсхүл тээвэрлэлтийн ачаалалд агаарын хөлөг нь тохирох эсэхийг харгалзан үзнэ.

УАОС-ын үнэлгээ нь зорьж байгаа агаарын хөлгийн хэмжээ болон жинд хамгийн тохирсон загварын стандартыг авч үзнэ.

ИНЕГ нь үйл ажиллагааны заавар, хязгаарлалт болон/эсхүл агаарын хөлгийг боловсруулж, бүтээсэн стандартын талаарх аливаа мэдээлэл орсон үйлдвэрлэгчийн баримт бичгийг авч үзнэ.

ИНЕГ-ын үнэлгээтэй холбоотой бусад хүчин зүйлс нь:

- тухайн агаарын хөлгийн санал болгосон хэрэглээ;
- агаарын хөлгийн маяг, төвөгшил, хэмжээ болон шинж чанар;
- ИНЕГ нь агаарын хөлгийн үйлдвэрлэгч болон/эсхүл загварыг мэддэг эсэх;
- тухайн агаарын хөлөг Монгол Улсад өөрийн төрлийн хувьд анхных нь эсэх;
- тухайн агаарын хөлгийн үйл ажиллагааны түүх, эсхүл агаарын хөлгийн загвар/маяг;



- тухайн агаарын хөлгийн загвар/маягийн гадаадын гэрчилгээ, эсхүл зөвшөөрөл;
- Монгол Улс, эсхүл гадаадад гарсан осол, эсхүл зөрчлийн статистик байна.

Илүү өргөн хүрээтэй, нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг боловсруулж гаргах хүртэл, зорилгод тохирсон туршилт болон/эсхүл баталгаа шаардах бөгөөд тохиолдол бүрд үнэлгээ хийнэ.

Далавчит агаарын хөлгийн хувьд, далавч болон сүүлний-тавцангийн статик ачааллын тестийг ашиглах нь гүйцэтгэхэд энгийн байх ба бүтцийн үнэлгээнд тусалж, бодитоор нийцэх болно.

RPAS-ийн ашиглахаар өөрчлөх маягийн гэрчилгээтэй агаарын хөлгийг өөрийн маягаар гэрчилгээжсэн статусыг (зохио байдлаар) хадгалж, техник үйлчилгээний байнгын зохицуулалтын шаардлагыг хангаж байна гэж үзэж болно.

Хэт хөнгөн агаарын хөлөгтэй адилхан хэмжээтэй хүнгүй агаарын хөлгийг хүнтэй хэт хөнгөн агаарын хөлөгтэй адил байдлаар авч үзнэ. ИНЕГ нь үнэлгээ хийх зааварчилгаа өгөхдөө олон улсын стандартыг ашиглаж болно.

Том агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь FAA стандарт болон/эсхүл Европын EASA загварын шаардлагыг зохио ёсоор авч үзэх хэрэгтэй. ИНЕГ-аас маш том хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхээр зорьж байгаа аливаа этгээдэд, тухайн стандартыг ашиглахаасаа өмнө зааварчилгаа авахаар ИНЕГ-т хандахыг зөвлөдөг.

### ***Аюулгүй байдлын нөөцийн/reduncancy бэлэн байдал***

Нислэгийг зогсоох шүхрийг тээвэрлэх нь аюулгүй байдлын хамгийн үр дүнтэй нөөц гэж үздэг бөгөөд энэ нь үйл ажиллагаа эрхлэгч хүнгүй агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой гол аюулыг бууруулах ялангуяа өмч хөрөнгө болон хүмүүсийн дээгүүрх нислэгийн эрсдэлийг удирдахтай холбоотой үзүүлэх арга хэрэгсэл юм.

Нислэгийг зогсоох шүхэр нь хуучин байдалдаа орох олон үр дүнгээс гадна эрсдэлийг бууруулах талаар Даргад итгэл төрүүлэх онцгой байдлын нөөц болно. Эдгээр шүхрийн систем нь өнөө үед олон-роторт зах зээлд гарах боломжтой болсон бөгөөд угсрах ажилд нэн тэргүүнд анхаарах ёстой.

### ***Шалгах/батлах нислэг***

ИНЕГ нь загварын стандарт бэлэн болох хүртэл үйл ажиллагаа эрхлэгчээс нислэгийн аюулгүй байдал, удирдлага болон найдвартай байдлыг үзүүлэх шалгах, эсхүл батлах нислэг хийхийг шаардаж болно. Хүсэлт гаргах явцын нэг хэсэг болгож, хүсэлт гаргагчаас найдвартай байдал, удирдаж болох байдал болон аюулгүй нислэгийн шинж чанарыг үзүүлэх тестийн бүсэд үйл ажиллагааны түүхийг үзүүлэхийг шаардаж болно. Энэ шаардлага болон ирээдүйн статистикийг мэдээлэх шаардлагыг хангахын тулд үйл ажиллагаа эрхлэгч нь хүнгүй агаарын хөлөгт шалгах, эсхүл батлах нислэгийн үед агаарын хөлгийн бүртгэлийн дэвтрийг бүх нисдэг хүнгүй агаарын хөлөгт хөтөлнө, үүнд аливаа шалгах, эсхүл батлах нислэг орно.

Агаарын хөлгийн бүртгэлийн дэвтэрт хамгийн наад зах нь дараах мэдээллийг тэмдэглэнэ:

- агаарын хөлгийн загвар болон серийн дугаартай таних тэмдэг;
- загвар болон серийн дугаартай хөдөлгүүрийн таних тэмдэг;
- хэмжээ болон маягаар суурилуулсан сэнс (-үүд);
- ашиглаж байгаа газрын удирдлагын станцын үйлдвэрлэгч, загвар болон серийн дугаар;
- бүрдэл хэсгийн дэлгэрэнгүйг багтаасан гэмтлийн болон засварын дэлгэрэнгүй мэдээлэл
- агаарын хөлөг болон бүрдэл хэсгийн үйлчилгээнд орох хугацаа/ашиглалтын цаг;
- аливаа хугацаатай, эсхүл их засвар шаардлагатай зүйлсийн дуусах хугацаа;
- аливаа холбогдох НТЧ-ын Удирдамж, эсхүл бусад үйлдвэрлэгчийн үйлчилгээний мэдээллийн tracking дэлгэрэнгүй;
- нислэгийн зорилго болон нисэх бүс;
- хөлгийн даргын ID;
- хамааралтай бол: харгалзах системийг солих гэх мэт үе шатны бус засвар үйлчилгээний удирдлагын систем;
- гүйцэтгэсэн бүх техник үйлчилгээний үзлэг болон хүний бүртгэл;
- агаарын хөлгийн дизайн, бүтэц, систем, эсхүл удирдлагад хийсэн аливаа өөрчлөлтийн бүртгэл;
- нөхцөл бүрээс шалтгаалан шаардах аливаа бусад өгөгдөл.

#### **102.11(b)(13) Ерөнхий зааврын нэмэлт, өөрчлөлт болон түгээлт**

Энэ шаардлагын хувьд, хүсэлт гаргагч нь Ерөнхий зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах үйл явцтай байх хэрэгтэй. Ерөнхий зааврыг хянах ажиллагааг хүчинтэй хуудасны жагсаалт (LEP) болон Ерөнхий зааварт орсон нэмэлт, өөрчлөлтийн цаг хугацааны дарааллаар тэмдэглэх боломжтой хуудсыг ашиглаж хийнэ. Нэмэлт, өөрчлөлтийн үйл явц нь өөрчлөлтийн үйл явцыг тэмдэглэх хяналтын хуудастай байна. Жнь: үүнд -

- нэмэлт, өөрчлөлтийн хэрэгцээ шаардлага;
- нэмэлт, өөрчлөлт нь эхлээд ИНЕГ-аас зөвшөөрөл авах хэрэгтэй эсэх (102.23-ыг харах);
- нэмэлт, өөрчлөлтийг (гол хүн) хүлээн зөвшөөрөх;
- хүчинтэй хуудасны жагсаалт болон нэмэлт, өөрчлөлтийн хуудсыг шинэчлэх;
- заавар эзэмшигчдэд түгээх (ИНЕГ-ыг оролцуулан).

#### **102.11(b)(14) Зөвшөөрөл**

Энэ нь үйл ажиллагаа эрхлэгчийг тухайн үйл ажиллагаатай холбоотой олгосон аливаа зөвшөөрлийг таниулахыг шаардана. Жнь: та DOC-ийн концесс, гэрээ, эсхүл нөлөөлөх үл хөдлөх хөрөнгийн эзэмшигчээс өгсөн зөвшөөрлийг нотлох баримт г.м таны ажиллагаанд найдаж болох аливаа зөвшөөрлийн нотлох баримтыг өгөх хэрэгтэй.

### **102.11(с) Лавлагаагаар хэрэглэх**

Хүсэлт гаргагч нь тухайн үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг эрсдэлийг удирдах арга зам болгон аливаа ИНД-ийн шаардлагын дагуу гүйцэтгэнэ гэж санал болгож болно. Жнь: хүсэлт гаргагч дүрмийн бүхэл шаардлагыг дэлгэрэнгүй дүрслэх шаардлагаас зайлсхийж, нийцлийн арга замын ишлэл болгон дүрмийн дугаар болон аливаа холбогдох заалтыг ашиглаж болно.

### **102.11(d) Даргын саналаар болох**

Энэ дүрэм нь Даргад үйл ажиллагааны зааварт шаардах агуулгыг хүсэлт гаргагчийн хүсэлт гаргасан үйл ажиллагааны төрөлд тэнцүүлэн өөрчлөхийг зөвшөөрнө. Энэ нь Даргад хүсэлт гаргагчийн эхний хүсэлтийн шаардлагыг тэдний үйл ажиллагааны эрсдэл болон нарийн төвөгтэй байдал руу тусгаж тохируулахыг зөвшөөрч байгаа болно.

Жнь: үйл ажиллагаа эрхлэгч нь зөвхөн ИНД-101-ийн хүрээнд ажиллахаар төлөвлөж байгаа боловч үйл ажиллагаандаа даатгалд хамруулах шаардлагаар хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшихээр зорьж болно. Дарга үйл ажиллагаа нь ИНД-101-ийн хүрээнд бол хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар нь 102.11(а)-д орсон бүх асуудлыг оруулсан шиг дэлгэрэнгүй байх хэрэггүй гэж шийдэж болно. Үндсэндээ, Дарга хүсэлт гаргагчийн Ерөнхий зааврын шаардлагыг тухайн үйл ажиллагаанаас гарах эрсдэлд нийцүүлэн тооцож болно.

### **102.13 Гэрчилгээ олгох**

Энэ дүрэм Дарга тухайн этгээд бүх үзүүлэлтийг хангаж байна гэдгийг баталж ИНД-ийн холбогдох дүрмийн дагуу үйл ажиллагааны гэрчилгээ олгох боломжийг олгоно. Дарга гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт нэмэлт журам оруулахыг шаардах, эсхүл гэрчилгээнд хавсаргасан гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны тодорхойлолтод шаардлага, эсхүл нөхцөл оруулж болно.

Үүнээс гадна, нисэхийн бичиг баримт эзэмшиж байгаа, эсхүл хүсэлт гаргасан этгээд нь тохирох, зөв хүн (FPP) гэдэгт Дарга сэтгэл хангалуун байх ёстой. Нисэхийн бичиг баримтад үнэмлэх, зэрэглэл, эсхүл агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ багтана. Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ нь нисэхийн бичиг баримт. Тохирох, зөв хүн үйл явцыг дор тайлбарласан.

ИНД-102-ын гэрчилгээ эзэмших хүсэлтийн нэг хэсэг болгож, 102.11(b)(i)-д шаардсан гол хүн нь тохирох, зөв хүн үнэлгээ хийлгэх шаардлагатай. Дарга мөн агаарын хөлгийн дарга болон үйл ажиллагаанд оролцдог бусад хүмүүсийг тохирох, зөв хүний үнэлгээ хийлгэхийг шаардаж болно.

### ***Тохирох, зөв хүн***

Тохирох, зөв хүн үнэлгээг нөхцөл байдал бүрд хийнэ. Аливаа тодорхой асуудал (эсхүл мэдээлэл)-д өгөгдсөн хамааралтай байдал болон ач холбогдол нь үйлчилж байгаа (нисэхийн системд оролцох түвшин) баримт бичгээс хамаарч өөрчлөгдөж болно. Иргэний нисэхийн системд нэг түвшний оролцоотой, жнь: хувийн нисгэгчийн үнэмлэх эзэмшихэд аливаа этгээд тохирох зөв хүн байж болох бүрэн боломжтой

боловч, тухайн системд дээд түвшний жнь: арилжааны нисгэгчийн үнэмлэх, эсхүл удирдлагын албан тушаал эзэмшихэд тохирох, зөв хүн байх боломжгүй.

Тохирох, зөв хүн тестийн үзүүлэлт байх ёстой ба үүнд дараах зүйлс багтана:

- хүсэлт гаргагчийн зам тээврийн аюулгүй байдал зөрчсөн хэрэг зөрчилд холбогдон ял эдэлж байсан бүртгэл;
- хүсэлт гаргагчийн тээврийн салбарт ажилласан туршлага;
- хүсэлт гаргагчийн нисэхийн хууль, дүрмийн шаардлагын талаарх мэдлэг;
- хүсэлт гаргагчийн тээврийн аюулгүй байдлын хууль, дүрмийн шаардлагыг биелүүлж байсан түүх;
- хүсэлт гаргагчийн биеийн эрүүл мэндийн, сэтгэцийн эрүүл мэндийн, эсхүл ноцтой зан байдлын хүндрэлтэй асуудлын түүх.

Тохирох, зөв хүний хүсэлтийн маягыг ИНЕГ-ын вебсайтаас авч болох <https://www.mcaa.gov.mn/Forms/24FPP.doc>, бөгөөд хүсэлт гаргагчийг Хууль зүйн дотоод хэргийн яамнаас эрүүгийн ял шийтгэлийн болон зам тээврийн осол, хэрэг, зөрчлийн бүртгэлээс түүхийн лавлагаа авчрахыг шаардана. Эдгээр лавлагааг авахад нилээд хугацаа шаардагдах бөгөөд хүсэлт гаргах үйл явцдаа аль болох эрт хүсэлт гаргах шаардлагатай.

### **Нисэхийн аюулгүй байдал**

Энэ дүрмээр гэрчилгээ олгох нь нисэхийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх бол гэрчилгээ олгохыг Даргад хориглоно. Өөрөөр хэлбэл гэрчилгээ олгох нь нисэхийн аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй байх ёсгүй. Энэ нь нисэхийн бүх аюулгүй байдалд хамаатай тул төлөвлөсөн хүнгүй агаарын хөлгийн үйл ажиллагаанаас хүнтэй нисэхийн системд үзүүлэх нөлөөг үнэлэх ёстой.

Аюул нь дараах байдалд хүргэх нөхцөл болно:

- агаарт, эсхүл газарт байгаа хүмүүсийг гэмтээх;
- агаарт, эсхүл газарт байгаа бусад агаарын хөлөг зэрэг үл хөдлөх хөрөнгийг гэмтээх;
- Монгол Улсын иргэний нисэхийн системийг тасалдуулах;
- агаарын зайн бусад хэрэглэгчдэд нислэгийн үйл ажиллагаанд аюул учруулж болзошгүй арга хэмжээ авах нөхцөл байдлыг бий болгох;
- цахилгааны дэд станц, аюултай агуулахын бүс, шорон г.м мэдрэмтгий бүсийн дээгүүр нислэг үйлдэх.

### **102.13(b)(1) Шаардлагууд**

Энэ дүрмийн дагуу Дарга гэрчилгээ олгохдоо үйл ажиллагааны нарийн төвөгтэй байдалтай холбоотой зайлшгүй гэж үзсэн аливаа шаардлагыг тогтооно.

Ерөнхий дүрмээр, нэмэлт шаардлага нь хүнгүй агаарын хөлгийн үйл ажиллагааны хэмжээ болон нарийн төвөгтэй байдал мөн хүнтэй агаарын хөлгийн үйл ажиллагааны аливаа ижил төстэй зүйлстэй тохирсон байх ёстой гэж үзнэ.

Жнь: үйл ажиллагаа эрхлэгч тэдний ажиллуулж болох аливаа том нарийн төвөгтэй RPAS-ийн техник үйлчилгээний хөтөлбөрийг 91.609-ийн дагуу гаргаж өгөх шаардлагатай байж болно.

### **102.13(b)(2) Нөхцөлүүд**

Энэ дүрмийн дагуу Дарга гэрчилгээ олгохдоо үйл ажиллагааны нарийн төвөгтэй байдалтай холбоотой зайлшгүй гэж үзсэн аливаа нөхцөлийг тогтооно. Хүнгүй агаарын хөлгийн хязгаар болон хамрах хүрээ нь их өргөн, тусгай үйл ажиллагаанд хамаарах нөхцөлийг ашиглах шийдвэрийг зөвхөн хүсэлт хүлээн авсан тохиолдолд гаргана. Дээр дурдсанаар 102.11(c)-д хүсэлт гаргагч нь үйл ажиллагаагаа эрсдэлийг удирдах арга зам болгон ИНД-ийн шаардлагын дагуу явуулахаар санал оруулж болно гэж заасан байдаг.

Иймд жижиг болон дунд хүнгүй агаарын хөлгийн хувьд дүрмүүд ерөнхийдөө хамаарахгүй бөгөөд энэхүү АС-ын эхэнд хэвлэгдсэн зааварчилгаа материал тэр үүргийг гүйцэтгэнэ.

Хөдөө аж ахуйн үйл ажиллагаа нь тээвэрлэж байгаа химийн бодисын аюултай шинж чанараас шалтгаалан дүрмийн нэг хасалт болдог бөгөөд ИНД-137-гийн холбогдох заалтыг хүнгүй агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний нөхцөл болгон харуулах ёстой гэж үзнэ.

### **102.13(b)(3) Тэмдэглэгээ**

ИНД-47-гийн тэмдэглэгээ шаардлагатай эсэхийг тогтоох Даргын энэхүү шаардлага нь 102.11(b)(7)-д орсон байгаа. Хэдийгээр энгийн зургийн шаардлага байхгүй ч ИНД-47-г биелүүлэх боломжтой гадаргуугийн талбайтай томоохон агаарын хөлөг энэ шаардлагыг мөрдөж болно. Одоогийн RPAS-ийн ихэнх нь ИНД-47-г биелүүлэх талбай байхгүй бүтэцтэй байдаг. Ийм тохиолдолд үйл ажиллагаа эрхлэгч гадна гадаргуугийн аль нэг хэсэгт үйл ажиллагаа эрхлэгчийг таниулсан байнгын тэмдэг тавих шаардлагатай.

### **102.15 Үйл ажиллагааны тодорхойлолт**

Үнэлгээ хийж дууссаны дараа ИНЕГ хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ олгох эсэхээ шийдэж болно. Үүнд зөвшөөрөгдсөн эрх, үйл ажиллагааны төрөл болон нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд оноосон аливаа нөхцөлийг тодорхой заасан Үйл ажиллагааны тодорхойлолтыг олгох талаар багтана.

Та Үйл ажиллагааны тодорхойлолт бэлтгэх шаардлагагүй. Энэ баримт бичгийг ИНЕГ гаргана. Таны үүрэг бол хүсэлтдээ Үйл ажиллагааны тодорхойлолтыг гаргахад шаардлагатай бүх мэдээлэл багтсан болохыг бататгах.

Хэдийгээр зарим нөхцөл нь бүх гэрчилгээнд түгээмэл байдаг ч үйл ажиллагаа эрхлэгч бүрийн Үйл ажиллагааны тодорхойлолтод орсон нөхцөл үйл ажиллагааны төрөл болон ашиглаж байгаа агаарын хөлгөөс хамааран өөр өөр байна.

### **102.17 Гэрчилгээ эзэмшигчийн эрх**

102.17(a) болон (b) нь үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээтэй хамт олгосон Үйл ажиллагааны тодорхойлолттой шууд холбоотой бөгөөд зөвшөөрсөн зүйлийн дэлгэрэнгүйг үзэхийн тулд Үйл ажиллагааны тодорхойлолт руу уншигчийг хандуул. Хэрэв Дарга Үйл ажиллагааны тодорхойлолтод үйл ажиллагаа эрхлэгчийг нэмэлт дүрэм мөрдөх ёстой гэж заасан бол дүрмүүд нь мөн, тэд дүрэм нь зайнаас удирддаг агаарын хөлөгт хамаарахгүй байсан ч мэдээж биелүүлэх ёстойг зааж байна.

### **102.19 Гэрчилгээний хугацаа**

Дүрэмд гэрчилгээг тав хүртэл жилийн хугацаатай олгож болно гэж заасан.

Анх удаа хүсэлт гаргагчдад Дарга ихэвчлэн зөвхөн хоёр жилийн хугацаатай гэрчилгээ олгох магадлалтай.

Ингэснээр Дарга үйл ажиллагаа эрхлэгчтэй харилцаа тогтоож, үйл ажиллагааны орчинд боломжит технологийн өөрчлөлтөөр хангах боломжтой хоёр жилийн хугацаанд ИНЕГ таны гүйцэтгэлийг үнэлэх зорилгоор хяналт, шалгалт хийж болно.

Хэрэв та одоогоор ИНЕГ (байгууллага)-ын гэрчилгээтэй бол ИНЕГ таван жилийн хүчинтэй хугацаатай гэрчилгээ олгож болно. Энэ бодлого нь тухайн байгууллагад иргэний нисэхийн бусад чиглэлд өөрийн чадамжаа харуулах боломж байгаа баримт болон үйл ажиллагаа эрхлэгч нь шинэ гэрчилгээний хүрээнд эрхээ хэрэгжүүлэхдээ өмнөх шигээ ажиллана гэдэгт Дарга итгэлтэй байхаар тусгасан.

### **102.21 Хүнгүй агаарын хөлгийн үйл ажиллагааны нөхцөл**

Энэ Дүрэмд гэрчилгээ эзэмшигчийг Үйл ажиллагааны тодорхойлолт нь ИНД-101-ийн тодорхой хэсгээс чөлөөлсөн, эсхүл өөрөөр зааснаас бусад тохиолдолд ИНД-101-ийн бүх шаардлагыг биелүүлэх ёстой гэдгийг тодорхой болгож байна.

Энэ нь цаашлаад гэрчилгээ эзэмшигчийг Ерөнхий заавар болон гэрчилгээнд хавсаргасан Үйл ажиллагааны тодорхойлолтод Даргаас тогтоосон аливаа нөхцөлийг биелүүлэхийг шаардана.

102.21(b) нь гэрчилгээ эзэмшигч тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд хийгдэж байгаа үйл ажиллагаанд оролцож байгаа бусад үйл ажиллагаа эрхлэгч, эсхүл ажилтныг хариуцна гэдгийг тодруулж байна. Мөн ажилтан нь Ерөнхий зааварт заасан журмыг бүрэн мэддэг ба Үйл ажиллагааны тодорхойлолтод заасан агуулга, нөхцөл, хязгаарлалтыг ойлгосон болохыг бататгах үүрэгтэй.

### **102.23 Ерөнхий зааварт өөрчлөлт оруулах**

Ерөнхий зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах журмыг Ерөнхий зааварт баримтжуулах шаардлагатай (102.11(b)(13)-ээс лавлах). Даргын зөвшөөрлийг урьдчилан авах ёстой болон ёсгүй гэсэн хоёр төрлийн нэмэлт, өөрчлөлт байдаг. Аль аль журмыг Ерөнхий зааварт оруулах нь зүйтэй.

Нэмэлт, өөрчлөлтийн хүсэлтийн маягт (CAA24102/02) нь анхны хүсэлтийн маягтаас тусдаа бөгөөд ИНЕГ-ын вебсайтын Маягт хэсэгт байгаа.

**102.25 Гэрчилгээ сунгах**

Энэ дүрэм нь өөрийгөө тайлбарласан байна гэхдээ сунгуулах хүсэлтийг боловсруулахад хангалттай хугацаа өгөхийн тулд та хүсэлтээ гэрчилгээний хугацаа дуусахаас 60 хоногийн өмнө өгөх ёстой.